

# ***ИРЭЭДҮЙГЭЭ БОД***

*Виллиям Макдоналд*

*Зохиогчийн эрх бүрэн хамгаалагдсан*

*Англи хэл дээр АНУ-д хэвлэгдсэн*

***ECS Ministries***

***Шуудангийн хайрцаг 1028***

***Dubuque, IA 52001***

***Цахим шуудан:***

***[ecsorders@ecsministries.org](mailto:ecsorders@ecsministries.org)***

***Цахим хаяг:***

***[www.ecsministries.org](http://www.ecsministries.org)***

Амьдралын минь бамбар Таны төлөө дүрэлзсэн учраас  
Амь юугаан өргөж, үхлээс үл айна би  
Хүч зүтгэл, хөрөнгө мөнгө, сайнмэдээний ажил,  
Хүнээс гарах юуг ч Танд өргөхдөө ихэд баярлана би  
Харгуй зам нь бартаатай гэхгүй би  
Хөлийн тань мөр намайг замчилсан нь хангалттай  
Амьдралын минь бамбар Таны төлөө дүрэлзсэн учраас  
Амь юугаан өргөж, үхлээс үл айна би  
Хүч зүтгэл, хөрөнгө мөнгө, сайнмэдээний ажил,  
Хүнээс гарах юуг ч Танд өргөхдөө ихэд баярлана би

- иш татав

©Зохиогчийн эрх Виллиям Макдоналдад хамаарна.

1956 он

## ГАРЧИГ

1. Амьдралыг өөрчилдөг үнэнүүд
2. Ганц л амьдарна
3. Дэндүү богинохон
4. Мөнхийн амьдрал
5. Амьдралын алтан үе
6. Мөнхөд үнэлэгдэх боловсрол
7. Ирээдүйгээ та сонгоно
8. Хүсэл зорилго чинь үнэхээр зөв үү?
9. Амьдралын зайлшгүй үүрэг хариуцлага
10. Амьдралын хамгийн чухал үүрэг
11. Ажил мэргэжил юунд хэрэгтэй вэ?
12. Шалтаг, шалтгаан тоочихуй
13. Гал халуун амьдрал



## АМЬДРАЛЫГ ӨӨРЧИЛДӨГ ҮНЭНҮҮД

Үнэн үг хүний амьдралыг өөрчилж чаддаг. Олон жил нэгэн хэвийн амьдарсан хүн тохиолдлоор ухаарал хайрласан өгүүлбэртэй таараад, цаашид огт өөр хүн болсон явдал олон байдаг. Түүний амьдралын зүг чиг өөрчлөгддөг.

Хадсон Тэйлорт ийм зүйл тохиолджээ. Тэрээр аавынхаа номын санд олон ном уншиж, эрэл хайгуул хийж явахдаа *"ХРИСТИЙН АЖИЛ БҮРЭН ДУУССАН"* гэдэг үгийг олж үзжээ. Энэ үнэн түүний сэтгэлийг эзэмдэв. Хэрэв Христийн ажил бүрэн дуусчихсан юм бол Аврагч Эзэнд итгэхээс өөр хийх зүйл түүнд үлдээгүй гэдгийг ойлгосон байна. Үүнийг ойлгосон даруйдаа сэтгэлд нь гэрэл гэгээ, амар амгалан ирэв. Ингээд хэдэн жилийн дараа тэрээр сайнмэдээ тунхаглахаар эх газрын Хятадыг зорьсон билээ.

Цинцендорф гүнд мөн ийм үйл явдал тохиолдсон. Тэрээр Германд залуу байхдаа нэг өдөр загалмайд цовдлогдсон Христийн зургийн өмнө зогсож байлаа. Зургийн доор *"Харагтун би үүнийг чиний төлөө хийсэн юм"* гэж бичсэн байв. Цинцендорф энэ үнэнийг ухаараад сэтгэл нь эмтэрч Есүс Христийг өөрийн Аврагч Эзэнээ болгон хүлээн авчээ. Зургийг дахиад хартал *"Чи миний төлөө юу хийсэн бэ?"* гэсэн үг бас бичээтэй байв. Сэтгэлийн гүнийг

онгичсон энэ асуулт Цинцендорфын амьдралыг өөрчлөхөд тэрээр Христийн төлөө бүх амьдралаа зориулсан юм. Өнөөдөр түүний нэр Моравийн илгээлтийн хөдөлгөөний түүхэнд чухал байр эзэлдэг.

Двайт Л. Мүүдийд мөн ийм үйл явдал тохиолдсон. Тэрээр Англид сайнмэдээ тараах аяныг дөнгөж дуусгаад Английн нэрт номлогч Хэнри Варлитай салах ёс гүйцэтгэх үед Варли түүнд *"Ноён Мүүди, хүслийг нь биелүүлэхээр Бурханд бүрэн бууж өгсөн хүнээр Бурхан юу хийж чаддагийг энэ дэлхий харахан үзээгүй л байгаа шүү"* гэж хэлжээ. Варлигийн үг Мүүдигийн санаанаас ер гарсангүй. Бодол сэтгэлийг нь бүрэн эзэмджээ.

"Энэ үгс Мүүдийг усан онгоцоор харих үед далайн давлагаанууд дээр бичигдсэн юм шиг, Нью Йоркийн гудамжаар алхаж явахад зам дээр сийлэгдсэн мэт, Чикаго уруу галт тэргээр явж байхад зөрөн өнгөрөх хангай дэлхийд зурагдсан юм шиг хаа ч явсан бодлоос нь гарсангүй." Варлигийн үг Мүүдигийн хойшдын амьдралыг өөрчилжээ. Түүнээс хойш Мүүдигийн юу хийснийг түүний үйл хэрэг, ажлынх нь үр дүн өөрөө гэрчилнэ.

Ийм түүхийг ярьж чадах мянга мянган хүн бий. Тэд амьдрал дундуур зүгээр л алхаж явахдаа гэнэтхэн урам, ухаан хайрласан чухал үнэнтэй учирдаг. Тэр үгийн

сэнхрүүлэг, ухаарал тэднийг эзэмдэж, бодол санаа, зүрх сэтгэлд нь гал ноцоодог. Түүнээс хойш тэд хэзээ ч өмнөх шигээ амьдардаггүй. Ухаарал хайрласан тэр үгс агуу алсын харааг өгч, Бурханы төлөө түүх бүтээлгэдэг.

Тэдэнд тохиолдсон явдал бидэнд ч тохиолдох боломжтой. Үнэн мөнхөд хэвээрээ бөгөөд тэдний амьдралд хувьсгал авч ирсэн үгс биднийг ч гэсэн нэгэн хэвийн амьдралаас чөлөөлж, энэ амьдралд ба ирээдүйн мөнхийн амьдралд үр жимстэй амьдруулж чадна.

Гагцхүү бид хүсэх ёстой. Бид үнэнийг ухаарахыг хүсэж байна уу? Үнэнтэй шударга бөгөөд зоригтойгоор нүүр тулахыг хүсэж байна уу? Утга учрыг нь бодож тунгаахыг хүсэж байна уу? Ухаарсан үнэнээ халуун сэтгэлээр хэрэгжүүлэхийг хүсэж байна уу?

Бүх зүйл энэ л хүслээс хамаарна. Үнэний өгдөг алсын харааг дагахад бид бэлэн үү? Тэгэхээр цаашаа уншихаасаа урьтаж Бурханы өмнө суугаад дараах асуултуудад хариулаарай:

*Эзэн надад үгээ хэлэхийг би хүсэж байна уу?*

*Би Эзэнийг ямар ч болзолгүйгээр дагах уу?*

*Эзэний төлөө огоорч чадахгүй зүйл надад байна уу?*

## ГАНЦ Л АМЬДАРНА

Энэ дэлхий дээр оршин байх тухайгаа бодож үзэхээр бид ганц л амьдарна гэдэг үнэнтэй нүүр тулах ёстой болно. Тиймээс "ГАНЦ Л АМЬДАРНА" гэдэг хөдөлшгүй үнэнээс эхэлцгээе.

Эзэн Есүс амьдралдаа үүнийг үргэлж санан явсан нь Иохан 9:4-т хэлсэн үгээс нь харагдана. "Намайг Илгээгчийн үйлсийг Би өдөр байхад хийх ёстой. Хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирж байна." "Өдөр байхад." "Шөнө ирж байна." "Ганц л амьдрал." Хэрэв энэ үгс улайссан төмөр мэт сэтгэлийг минь төөнөх аваас бидэнд цорын ганц амьдрал байдгийг бид хэзээ ч мартаж чадахгүй. Ямар их бодууштай зүйл вэ!

Бид юуны түрүүнд амьдралын *үнэ цэний* тухай бодох ёстой. Амьдрал минь надад хэр их үнэтэй вэ? Амиа би хэдэн төгрөгөөр сольж чадах вэ? Мэдээж хэн ч амиа мөнгөөр үнэлэхгүй. Амь амьдрал минь бидэнд үнэлж баршгүй үнэ цэнтэй.

Мөн бид амьдралын *боломжуудын* тухай бодох ёстой. Хорвоод мэндэлсэн хүн Иохан ч болж болно, Иудас ч болж болно. Паул ч болж болно, Пилат ч болж болно. Амьдралыг сайны төлөө ч ашиглаж болно, бузар муугийн төлөө ч ашиглаж болно. Хүн үр жимстэй ч амьдарч болно,



амьдралаа үрэн таран хийх ч боломжтой. Аз жаргал ч болгож болно, аймшигт там ч болгож болно. Амьдралд асар их нөөц боломж оршдог.

Энэ бүхнийг ухаарах аваас амьдрал гэдэг туйлаас хариуцлагатай зүйл бөгөөд түүнийг үрэн таран хийж болохгүй, харин хамаг чадлаараа үр дүнтэй ашиглах хэрэгтэйг ойлгож чадна.

*Хий хоосонд зугаацаж явах нь  
Хүний ажил биш ээ анд минь  
Дэндүү богинохон юм энэ амьдрал  
Дэлхий ертөнцөд дүүрэн юм нүгэл  
Унаж буй навч, дусаж буй нулимс шиг  
Урсаад одчихдог юм бидний нас  
Цэнгэл жаргалд ташууран назгайрахад  
Цаг хугацаа давчуухан юм анд минь  
Харанхуй энэ ертөнцөд  
Хичээж зүтгэх ёстой шүү  
Олон амь, дахих амьдрал байхгүй  
Олдсон ганц амьдрал үнэ цэнтэй шүү  
Бурханы хүслийг тэргүүнд тавиад  
Бусдыг аврахад ханцуй шамлаад  
Бидэнд өгөгдсөн богинохон хугацаанд  
Бүгд хамтдаа хичээнгүй ажиллацгаая  
(Хоратиус Бонар)*

"Олон амь." "Ганц амьдрал." "Богинохон хугацаа." Энэ үгсийг сонсохоор ганц амьдралын үнэ цэнийг ойлгуулах гэж Ч. Э. Татэмийн хэрэглэдэг жишээ эрхгүй санаанд ордог. Ээж охин хоёр дэлгүүрээс хүнсээ цуглуулж байлаа. Авах юмаа бүгдийг нь авсны дараа ээж нь охиндоо нэг зоос өгч чихэр авч идэхийг зөвшөөрчээ. Охин чихрийн лангууны өмнө зогсоод тэр олон чихрийн дунд тээнэгэлзэн байснаа "Би энийг авмаар байна" гээд нэг чихэр рүү заав. Худалдагч чихрийг авч өгтөл охин бодлоо өөрчилж, "За за биш юм байна, тэрийг авъя" гэлээ. Энэ мэтчилэн хэд хэдэн удаа шийдвэрээсээ эргэж буцахад ээж нь цухалдан, "Охин минь хурдалж үз. Аль нэгийг нь л хурдхан авчхаач дээ" гэж хэллээ. Хариуд нь охин "Ээж ээ, зарцуулах ганцхан л зоос байгаа шүү дээ" гэж хэлсэн нь бидэнд нэгийг бодогдуулна.

Бидэнд ганцхан зоос, нэг л амьдрал бий. Үүнийгээ ухаалгаар зарцуулцгаая.

Үүнийг бид байнга өөрсдөдөө сануулж байх хэрэгтэй. Их Британийн хаан Жорж V үүнийг өөртөө сануулахыг тулд 19 дүгээр зууны Америкийн квакерчуудын нэг Стефин Греллэтийн бичсэн үгийг ширээн дээрээ байлгадаг байв. Тэр үгийг энд иш татъя. "Би энэ ертөнцөөр ганц л удаа өнгөрөн явна. Тиймээс хэн нэгэнд хийж өгч чадах аливаа сайн зүйл

байвал түүнийгээ одоо л хийе. Дахиж энэ замаар өнгөрөхгүй учраас тэр боломжийг үл тоох юм уу хойш тавихгүй байя."

Дэлхий дээр өнгөрүүлэх ганц олдсон амьдралаа хэрхэн зарцуулах тухай Эвис Б. Крисчиансен нэгэн шүлэгтээ өгүүлсэн.

*Намайг Аврагч, Эзэн Хаан Есүс минь ээ  
Надад Танд өгөх ганц л амьдрал байна  
Нигүүлслийг тань дуулах ганц л хэл байна  
Надаас Танд зориулах ганц л зурх байна*

*Эгнэшигүй хүчит Алдрын Хаан Есүс минь ээ  
Энэ л бие минь зөвхөн Танд зориулагдах болтугай  
Энэрэл, хайр, нигүүлслийн Эзэн Есүс минь ээ  
Энэ л мөчүүд минь зөвхөн Танд ашиглагдах болтугай*

*Хөөрхий сүнснүүд нүгэл ба ичгүүр дотроо үхэж  
Халуун там уруу мөхлийн замаар явж байна  
Өнгөрч буй мөч бүхнийг зарцуулахдаа  
Өнө мөнхийн утга учиртай байлгах юмсан*

*Голготын авралыг тэдэнд дуулгах юмсан  
Гарцаагүй үнэн хайрыг тань мэдүүлэх юмсан*

*Ганц амьдралд нь Таны тухай ярих юмсан  
Гайхамшигт сайнмэдээг нэрээр тань хүргэхэд туслаач*

*Танд өргөх ганц л амьдрал байна, хайрт Эзэн минь  
Түүнийг минь хүлээж аваач гуйя Их Эзэн минь  
Таны хүслийг дуулгавартай дагахаас өөр юу ч  
Тээнэгэлзүүлж намайг хойш чангааж чадахгүй*

*Өөрийн гэсэн бүхнээ Та надад өгсөн  
Өршөөл нигүүлсэл, хайр энэрлээ өгсөн  
Өөрийн амьдралаа Таны төлөө ашиглая  
Өдөр бүр, хором мөч бүхнээ Тандаа зориулъя*

Тэгвэл одоо, ганц л амьдарна гэдэг энэхүү агуу үнэнтэй нүүр тулж, бидний одоогийн үйл хэрэг, хүсэл тэмүүллийг энэ өнцгөөс харвал үнэ цэнтэй байна уу гэдгийг шударгаар тунгаацгаая.

## ДЭНДҮҮ БОГИНОХОН

Ганц амьдарна гэдгээ бодож үзэх хэчнээн чухал болохыг сая ярилаа. Тэгвэл амьдралын хугацааг бодох нь бүр ч чухал биш үү? Бидний амьдрал дэндүү богино. Хүн олдсон ганц амьдралдаа мянган жил, таван зуун жил, хоёр зуун жил амьдардаг бол нэг их яарахгүй биз ээ. Гэвч бид зуун жилийн дараа гэхэд бүгдээрээ энэ дэлхий дээр оршин байхаа болино. Хагас зуун жилийн дараа гэхэд ихэнх маань байх эсэх нь эргэлзээтэй. Үүнийг хөнгөн үзэх ямар ч аргагүй.

Бид хэр удаан амьдрах вэ? Библид хэлсэнчлэн хүний дундаж нас далан жил. (Дуу 90:10) Та тийм удаан амьдрах байлаа гэж бодъё. Гэхдээ эхлээд түүнээс одоогийн насаа хасах ёстой. Тэгж байж цаашид амьдрах жилүүдийн тоо гарна. Гэхдээ тэгээд дуусчихгүй. Үлдсэн жилүүдээсээ унтах, ажил хийх, өвчин тусаад орондоо хэвтэх хугацааг хасах ёстой. Ингээд бодохоор Есүс Христийн төлөө үйлчлэх чөлөөт цаг бидэнд хэр их үлдэж байна? Тийм ч их цаг үлдэхгүй.

Библид хэд хэдэн удаа амьдралыг хоромхон зуурынх гэж хэлсэн.

Моше түүнийг унтах нойртой харьцуулсан.

Давид түүнийг сүүдэр мэт гэж өгүүлсэн.

Иов түүнийг нэхмэлчний зүүтэй адилтгасан.

Иаков түүнийг уур манан хэмээн дүрсэлсэн.

Петр харин гандах өвс гэж хэлсэн.

Амьдрал нүд ирмэхийн зуур өнгөрөн одож, бүхий л сайн сайхантайгаа дуусгавар болдог.

Энэ дэлхий дээр мөнх амьдрах юм шиг санадаг мунхаг хандлагыг минь булш бунхан, оршуулгын газар дооглон инээдэг. Өдөр өнгөрөхийн төдийд "Хүүхдийн ор, авс хоёрыг нэг л модноос урладаг" гэсэн үг үнэн гэдгээ харуулна.

Христигэгч хүн үхлийг биш Эзэний хоёр дахь ирэлтийг бодож амьдардаг хэмээн зарим нэг нь маргаж магадгүй. Тэгж хэлсэн ч амьдралын тодорхойгүй байдал үнэн гэдгийг улам батална. Зарим хүн өөрийгөө арай үхэх болоогүй, дахиад хэдэн арван жил амьдарна гэж бодож болох юм. Гэтэл Аврагчийн хоёр дахь ирэлтийн тэмдэг болсон уухайн дуу, Бурханы бүрэн дуу өнөөдөр дуугарахгүй гэсэн баталгаа хаана байна? Улс төрийн байдал, ёс суртахууны доройтол Библийн зөгнөлүүд хамтдаа Эзэний ирэлт ойртож буйг илтгэдэг бус уу? Тэгэхээр бидэнд тийм их цаг байгаа гэж үү?

Юу хэлэх гээд байна вэ гэвэл, Бурханы төлөө амьдаръя гэсэн хүн цаг хугацааг хэзээ ч алдаж болохгүй. Минут

секунд болгоныг Бурханы хариуцуулсан ариун зүйл гэж үзэн, цаг мөч бүрийг үнэ цэнтэйд тооцох хэрэгтэй. Өдөр бүрийг Христийн шүүх суудлын өмнө зогсох өдөр мэт үзэн ажил төрөл, үйл хэргээ төлөвлөж байх хэрэгтэй.

Македоны Филипт зарц охин өглөө бүр "Филип ноёнтоон, та үхнэ гэдгээ битгий мартаарай" гэж хэлдэг байжээ. Филип өдөр бүр зугтах аргагүй энэ үнэнийг бодон санан явдаг байлаа.

Ариун Сүнс бидэнд ч бас өглөө болгон Библээр дамжуулан "Үдийн наран мэт зуурдын амьдралтай тоос шороо төдийхөн" гэдгийг минь сануулдаг. Бид мөнхийн амьдралыг бодож амьдрах ёстой.

*Цаг хугацааг үнэлж сурахад туслаач*

*Цалгардуулж үрэх мунхаглалаас хамгаалаач*

*Уй гашиуг минь үүрдэг Христэд найдуулж өгөөч*

*Үхсэн ч амьдарсан ч Таны төлөө л байхсан*

*Бүх өдөр минь Та алдаршаач Эзэн Есүс ээ*

*Бүх замд минь Та удирдан чиглүүлээч*

*Өөрийн хүссэнээр намайг дагуулаач Эзэн Есүс ээ*

*Үхэлд ч амьдралд ч Христийн төлөө л байхсан*

*Та өнөөдөр, маргааш, ирээдүйнхээ талаар юу төлөвлөж байна вэ? Дараа нь яах вэ?*

## МӨНХИЙН АМЬДРАЛ

Зуурдын энэ амьдрал ийм бодитой юм бол төгсөшгүй мөнхийн амьдрал бүр ч бодитой байх бус уу? Хүн төрөлхтний үгийн сангаас үүрд мөнхийг бүрэн илэрхийлэх үг олохгүй. Мөнхийн цаг хугацаа гэж юу болохыг жаахан ч гэсэн ойлгоё гэвэл орчлон ертөнц бүтээгдэхээс өмнө, тэнгэрэлч нар буй болохоос ч өмнө, Бурханаас өөр хэн ч байгаагүй цаг хугацаа уруу эргээд оч. Бүр түүнээс ч цаашаа яв. Эхлэлгүй эхлэл уруу оч. Түүнээс цааш яваад л бай. Бурхан үргэлж байсан. Түүнд эхлэл гэж үгүй.

Дараа нь оюун санаагаа ирээдүй уруу чиглүүл. Энэ дэлхий сөнөж устаад, нүгэл хилэнц зайлуулагдаад, цаг хугацаа үгүй болсон тэр үе рүү оч. Цаашаа яваад л бай. Хэчнээн явсан ч төгсгөл гэж байхгүй.

Энэхүү мөнхийн цаг хугацааг бүгдийг нь багтааж бодъё гэсэн ч бидний оюун санаа даанч хүрэхгүй. Ухаан санаанд ч багтамгүй ийм мөнх амьдралаар амьдарна гэдгээ та бодоорой. Төгсгөлгүй, дуусашгүй, үүрдийн амьдрал шүү! Энэ бол мөнхийн цаг хугацаа.

Ийм ойлгошгүй зүйлийг хүн бид бүрэн ойлгох юм шиг мунхагладаг нь үнэхээр инээдтэй. Жишээлбэл Хэндрик Ван Лүүн мөнхийн цаг хугацааны тухай утгагүй дүрслэлийг бичиж үлдээсэн: "Свитиод нэртэй хойд зүгийн нутагт өндөр



уулын оройд нэгэн том хад байдаг. Энэ хад зуун бээр өндөр, зуун бээр өргөн. Мянган жил тутамд энэ хадан дээр нэгэн бяцхан шувуу ирж хошуугаа хурцалдаг байв. Ингэж явсаар хэзээ нэгэн өдөр хад элэгдэж дуусахын адил өдөр хоног нь нэгээр хорогдсоор мөнхийн цаг хугацаа ч дуусах болно."

Ровлэнд Диксон Эдвардс мөнхийн цаг хугацааны тухай бас өөрийнхөө ойлголтыг бичиж үлдээсэн. Тэр ингэж бичжээ: "Далай тэнгисийг нэгэн том саван дотор багтаалаа гэж бодъё. Тэр савны гадна тал бяцхан цорготой. Цорго далайн усыг дусал дуслаар гоожуулна. Хэчнээн удаан ч гэсэн далай хэзээ нэгэн цагт шавхагдаж дуусна. Үүн шиг, мөнхийн цаг хугацааны өдөр хоногууд нэг нэгээр өнгөрсөөр хэзээ нэгэн цагт заавал дуусна."

Мөнхийн амьдрал бол эрэггүй далай, төгсгөлгүй цаг хугацаа, үүрдийн одоо, Бурханы амьдралын хугацаа юм. Мөнхийн цаг хугацааг илэрхийлж чадах нэг ч үг байхгүй.

Энэ дэлхийн амьдрал маань хязгаар үгүй мөнхийн цаг хугацааны далайн эргийн элсний нэгэн ширхэг төдий гэдгийг бодож үзээгүй хүн хэзээ ч амьдралын утга учрыг зөвөөр ойлгохгүй. Хүн амьдралаа энэ өнцгөөс харах ёстой. Мөнхийн цаг хугацааг бодож амьдралынхаа зорилгыг тодорхойлох ёстой.

Миланы цогчин дуганд гурван зэрэгцээ хаалга байдаг. Эхний хаалга дээр цэцгэн хээ хуар байхын хажуугаар "Биднийг баярлуулдаг бүхэн нэгэн хормынх" гэсэн бичиг бий. Гурав дахь хаалган дээр загалмай байна. Мөн "Биднийг зовоодог бүхэн нэгэн хормынх" гэсэн бичигтэй. Харин дунд хаалган дээр "Мөнхийн зүйл л хамгийн чухал" гэсэн сануулга сийлээстэй байдаг.

Христитгэгч бид мөнх амьдарна гэсэн үнэнийг бодож амьдрах учиртай хүмүүс. Гагцхүү мөнхийн цаг хугацааг найдвараа болгож амьдарваас нүдэнд минь огт өөр зорилго харагдаж, зүрхэнд минь огт өөр шийдвэрүүд төрнө. Хийх ажил маань зөвхөн энэ амьдралаар дуусахгүй гэдгийг ухаарна. Бид одоогийн төлөө бус, үүрд мөнхийн төлөө амьдарч эхэлнэ.

## АМЬДРАЛЫН АЛТАН ҮЕ

Амьдралын чухал асуудлуудтай шударгаар нүүр тулахыг хүсэж буй залуу итгэгчдэд хандаж хэлэхэд, залуу нас бол амьдралын алтан үе юм шүү! Энэ насандаа хүний чадал тэнхээ оргил үедээ, сэтгэл санаа ариунаараа, хүсэл тэмүүлэл оргилуунаараа байдаг. Бурхан залуу насыг онцгойлон үздэг нь Иеремиа 2:2-оос тодорхой харагдана. "Залуу үеийн чинь зориулалт, сүйт бүсгүйнх мэт хайрыг чинь, тариалаагүй газар нутаг болох цөлд хүртэл Намайг дагаж байсныг чинь Би санаж байна."

Залуу насанд ямар нэг онцгой зүйл бий. Нас биед хүрсэн муураас илүү бяцхан зулзагыг бид өхөөрдөг. Талд бэлчих адуун сүргээс унаганууд нь бидний хайрыг татдаг. Хаа ч очсон балчир хүүхдүүд сэтгэл дэвтээж, тэднийг битгий хөгшрөөсэй гэсэн далд хүсэл дотор минь төрдөг.

Сүнслэг талбарт ч мөн адил. Бурхан залуу насны гал дөл, анхны хайрын халуун элчийг онцгойлон таашаадаг. Залуу хүний хүч чадал, хичээл зүтгэл, зориг зүрхэнд Бурхан дуртай. Бурханы төлөө гаргаж чаддаг зориулалт, тэвчээр хатуужил, сайн дураараа бүхнийг огоорч чаддаг эрс шийдэмгий занг Бурхан дурсан санадаг. "Залуу үеийн чинь зориулалт, сүйт бүсгүйнх мэт хайрыг чинь Би санаж байна."

Залуу нас бол хийж бүтээхийн оргил үе. "Гуч хүрээгүй байхдаа Виржил латин яруу найргийн оргилд хүрч, Лютер шашны шинэчлэлийг удирдаж, Ньютон эрдэмтдийн дунд тэргүүн эгнээнд орсон. Хорин найм хүрэхээсээ өмнө Херодотус олимпын тэмцээнд түүхийн есөн номоо уншиж, Ганнибал Испанийг Карфагены захиргаанд оруулсан. Хорин таван настайдаа Демостенэс Грекийн алтан амт, Цецерон Ромын мөнгөн хэлт гэгдэж явжээ. Харин Рафаел хорин таван насандаа уран зургаараа II Юлийг бишрүүлсэн бөгөөд түүний зураг одоо ч Ватиканд хадгалагдаж буй. Энэ насан дээрээ Галилей шөнийн тэнгэрийг дурандаж, шинэ оддыг нээж байлаа. Харин Шекспир жүжгийн зохиолчдын манлай болсон юм. Хорин хоёр настайдаа Александер Персийн эзэнт гүрнийг унагасан бол, Напелион, Вашингтон нар цэргийн гарамгай жанжин болцгоосон. Плато хорин насандаа Сократын дотнын найз, шавь болсон ба арван долоон настай Аристотелийг сургаж явав. Паскал арван есөн настайдаа агуу математикч болсон. Бекон индактив гүн ухааныхаа суурийг тавьж байхдаа тэр л насан дээрээ байлаа. Жонатан Эдвардс, Жорж Вайтфилд нар хорин таван насандаа агуу номлогчдын тоонд орж явсан. Есүс Христ гучин насандаа энэ ертөнцөд хувьсгал авчрах сайнмэдээгээ тунхаглаж явав."

Тэгвэл өтөл нас ирэхэд бидний хамаг хүч чадал харьсан байдаг. Гар хуруу минь салгалж, хөл минь биеийн жингээ даахаа больж, магад цөөн хэдэн шүд үлдэж, нүдний хараа муудна. Чих маань тусгай төхөөрөмжөөр сонсож, хэл яриа маань түгдэрч гацна. Нас ахих тусам бидний зориг зүрх мохож, сэтгэлийн гал бөхөж, дур хүсэл ч унтран бие махбод маань доройтдог.

Библи энэ талаар ямар үнэн үг хэлээ вэ! "Хүнд өдрүүд ирж 'Надад аятай юм алга' гэж хэлэх тийм жилүүд ирэхээс өмнө залуу насныхаа өдрүүдэд, Бүтээгчээ санагтун." (Ном 12:1)

Залуу нас бол Эзэнийг санах үе мөн. Зөвхөн аврагдахын тулд ч биш, бас Эзэнд үйлчлэхийн төлөө Эзэнийг сана.

Христитгэгч залуучууд аа! Хөгширсөн хойноо хийж чадахгүй боловч залуу насандаа та нар бүхний хийж чаддаг зүйл байдаг юм шүү. Залуу хүний гэрчлэл залуучуудад хүчтэйгээр хүрдэг. Хүмүүс залуу насны эр зориг, хичээл зүтгэлд татагддаг. Харин настай хүмүүсийг тийм зан гаргахад хэт туйлширч байна гэж бодоцгоодог. Залуу хүмүүс эрсдэлээс айдаггүй бөгөөд аливаа тулааны бэрхшээл рүү үсрэн ороход бэлэн байдаг бол, настай хүмүүс тэмцэл зөрчлөөс болгоомжилдог.

Олон итгэгч ирээдүйд мөнгөтэй болсныхоо дараа эсвэл тэтгэвэрт гарахаар буюу хөгшрөхөөрөө Христийн төлөө амьдарч эхэлнэ гэдэг утгагүй бодол тээж явдаг.

Бурхан юмны адаг сүүлийг хүсдэггүй. Харин охь шимийг бүгдийг нь хүсдэг. Хуучин Гэрээн дээр Бурхан төгс, өө толбогүй тахил шаарддаг байлаа. Энэ шаардлага одоо ч өөрчлөгдөөгүй. Түүнд бид муудаж элэгдсэн, хуучирсан, хүч чадалгүй өргөл өргөж чадах уу? Үгүй. Учир нь гэвэл, Бурхан бидний хамгийн сайныг авахыг хүсдэг. Бидний хамгийн сайн нь залуу нас билээ.

*Эзэн Христ хамгийн сайныг хүсдэг.*

*Эрт дээр цагт хүслээ мэдүүлэхдээ*

*Үр төлийн ууганыг Тэр шаардсан*

*Үр тарианы сорыг Тэр нэхсэн*

*Өөрийн хүмүүсийн охь сайныг хүсдэг гэж*

*Өнөө цагт хүслээ Тэр ойлгуулсан*

*Шилдэг чадвар, оргил үеийг Тэр хүссэн*

*Шуудхан хэлэхэд хамгийн сайныг нь шаардсан*

*Гэхдээ мэдээж Тэр шударга Бурхан*

*Гарцаагүй Тэр үнэн Бурхан*

*Дорой хүний үйлчлэлийг Тэр мартахгүй*

*Даруу хүний хайраас Тэр татгалзахгүй*

*Христ бидэнд хамгийн сайныгаа өгсөн*

*Хайрт хүүхдүүдийнхээ өргөсөн зүрхийг аваад  
Харин оронд нь жавхлант гоо үзэсгэлэн  
Хөөр баяр, амар тайвнаараа дүүргэдэг.  
Ертөнцийн хамгийн агуу баялаг Түүний дотор бий  
Есүс Христээс бид хамгийн сайныг нь авсан  
Тэнгэрийн хамгийн сайн бэлгүүд Түүний дотор бий  
Тэрхүү Христээс бид хамгийн сайныг авсан  
Дуусашгүй агуу энэ хайрыг тань харуулахаар  
Даруугаар үйлчлэх тусмаа бид хүчирхэгждэг  
Дундаршгүй их авралыг тань тунхаглахаар  
Дуудлагаа биелүүлэх тусмаа бид өсөж хөгждөг  
Хамгийн сайныгаа Түүнд өгөх нь  
Харамламаар их үнэтэй гэж үү, бодоод үзээч!  
Эзэн минь бидний төлөө модон загалмай дээр  
Эрэлхгээр амиа өгөөгүй гэж үү, бодоод үзээч!  
Орчлон ертөнцийг Бүтээгч, эздийн Эзэн  
Огтхон ч буцалтгүй зовлон шаналлыг туулан  
Хамгийн сайныгаа бидэнд өгсөн биш үү!  
Харьцуулж харвал бидний өгөх хамгийн сайн нь  
Хөөрхийлөлтэй өчүүхэн байгаа юм биш үү!*

1956 оны 1 сарын 8-нд Эквадорт итгэлийнхээ улмаас  
амиа алдсан 27 настай христитгэгч залуу Петр Флэймин

амьдралынхаа хамаг шилдэг сор бүхнийг Эзэнд өгөхийг хүсдэг байлаа. Тэрээр залуу насныхаа хүч чадал, авьяас чадвар, хайр, амь амьдралаа, хамгийн сайныг нь Христэд зориулахаар хатуу шийджээ. Энэ шийдвэр нь түүний дуртай дуунд маш сайхнаар илэрхийлэгдсэн.

*Хүч чадал минь оргилдоо байхад Эзээн*

*Таны төлөө би хүчээ зориулъя*

*Сэтгэл зүрх минь оргилуун байхад Эзээн*

*Тандаа би шинэ дууг зохиоё*

*Энэ ертөнцөд би зүрхээ өгчхөөд*

*Дараа нь Танд хайртай гэж хэлэхгүй*

*Хүч чадал минь барагдчихаад*

*Дараа нь Танд үйлчилнэ гэж хэлэхгүй*

*Гал халуунаар шатаж явахдаа*

*Ертөнцөд өөрийгөө зориулчихаад*

*Хүч минь доройтож нас минь өтлөхөөр*

*Тэнгэрийн төлөө үйлчилнэ гэхгүй*

*Та миний унтарсан сэтгэл*

*Бөхсөн бүлээн хайрыг хүртэх Нэгэн биш ээ*

*Харин миний халуун сэтгэл*

*Шатсан зүрхийг авах зохистой Нэгэн билээ*

*Зөвхөн амьдралын минь алтан үе дээр намайг сонгооч*



*Зүрх сэтгэл минь булиглаж байхад намайг ашиглаач  
Залуу насанд минь намайг хэрэглээч  
Зүрх минь дүүрэн байхад надаар Та өөрийгөө  
алдаршуулаач*

(Томас Х. Гилл)

Залуу насыг үрэн таран хийхээс өөр эмгэнэл гэж үгүй. Тиймээс та өнөөдөр өөрөөсөө асуу. "Залуу насны минь намтар ямар байх вэ? Бурханы юманд бүлбэгэр байсан гэж дурсагдах уу? Эсвэл Эзэн Есүсийн төлөө амьдралаа гал халуунаар зориулсан гэж бичигдэх үү?"

*Таны намтар өнөөдөр ч гэсэн бичигдэж байгааг битгий мартаарай.*

## МӨНХӨД ҮНЭЛЭГДЭХ БОЛОВСРОЛ

Боловсролыг бурханчлан шүтдэг энэ эрин үед залуу итгэгчид мэдлэгийн хойноос хөөцөлдөхөөсөө өмнө сурч мэдэхийн утга учрыг зөв үнэлж дүгнэхэд чиглүүлэг болох хэд хэдэн үнэнийг мэдэж байх хэрэгтэй.

Нэгдүгээрт, диваажинд очих хүртлээ бид төгс мэдлэгт хүрч чадахгүйг хүлээн зөвшөөрөх. Зөвхөн Бурхан бүхнийг мэднэ. Бүхнийг мэдэх нь гагцхүү Бурханд байдаг чанар. Бид хэзээ ч Бурхан болохгүй учраас суралцах явцаас ангижрахгүй. Үүнийг ухаарч гэмээ нь мөнхийн амьдралд бид хэрхэн бэлтгэхээ ойлгоно.

Диваажинд бид суралцсаар байх болно гэдгийг Библи хэлдэг. Жишээлбэл Ефес 2:7 дээр, "Христ Есүс дотор бидэнд хандсан Түүний нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд Бурхан үзүүлнэ" гэж Паул хэлсэн. Хэрэв Бурхан ямар нэг зүйлийг мөнхөд илчлэх юм бол бид ч тасралтгүй суралцсаар байх нь тодорхой. Тийм байхаас ч аргагүй юм. Бурхан Өөрөө хязгааргүй бөгөөд яруу алдар нь дуусахгүй учраас Түүний тухай бүрэн суралцаж хэзээ ч чадахгүй. Сатан энэ дэлхийн бүх яруу алдрыг Эзэн Есүст нэг хормын дотор үзүүлсэн бол, Бурханы үзүүлэх Есүс Христийн хэмжээлшгүй баялаг нь хэмжээ хязгааргүй тул түүнийг хэзээ ч мэдэж дуусахгүй. Бид гайхамшигт хайрыг

танин мэдсээр, Бурханы өлмийд суугаад зогсоо зайгүй сурсаар байх болно.

Бид мөнхийн улсад очихоороо бүхнийг мэддэг болно гэж ойлгогдохоор хоёр эшлэл бий. Иохан нэгдүгээр захидалдаа, бид Христ шиг болно гэсэн. Гэвч энэ нь царай төрхийн хувьд ижил болохыг яриагүй. Мэдлэг ухааны хувьд ижил болно гэсэн үг ч биш. Харин ёс суртахуун, ариун шударга зангаараа адил болохыг хэлсэн. Бидний дотор ямар ч нүгэл оршихгүй болж, бид нүглээс үүрд чөлөөлөгдөх учраас Түүнтэй адил болох юм.

1Коринт 13:12 дээр "Биднийг мэддэг шиг бид ч бас мэдэх болно" гэж Паул хэлсэн. Энэ нь мөнхийн улсад очихоороо бүхнийг мэднэ гэсэн үг биш. Харин мөнхийн улсад очихоороо хайртай хүмүүсээ бүрэн танина гэсэн утгатай. Бид бүтээлүүд. Тиймээс Бүтээгчээс үргэлж доор байх ба хязгаарлагдмал мэдлэгийг л эзэмшинэ.

Хэрэв бид мөнхийн улсад тасралтгүй суралцсаар байх юм бол тэнд очихдоо ямар мэдлэгтэй байх вэ гэсэн асуултыг асууж болох юм. Миний үзэж байгаагаар энэ ертөнцийг орхихдоо ямар мэдлэгтэй байсан тэр л мэдлэгтэйгээ мөнхийн улсад очно. Мэдээж тэр мэдлэгээ ирэх үеүдэд нэмэгдүүлэх боломжтой. Гэхдээ энэ ертөнцийг орхихдоо ямар мэдлэгтэй байсан, тэр л мэдлэгээсээ эхэлнэ.

Хэрэв энэ нь үнэн бол туйлын чухал ач холбогдолтой. Тэнгэрт очоод хэрэг болохгүй энэ дэлхийн боловсролыг эзэмших гэж хамаг амьдралаа зориулах хэчнээн мунхаглал болох нь эндээс харагдана. Та шинжлэх ухаан, утга зохиол, улс төрийн аль нэг салбарыг бусдаас илүү сурч мэдэх амьдралын зорилго тэмүүлэлтэй байж болох юм. Түүндээ ч хүрлээ. Гэвч тэнгэрт очсоны дараа тэр их хичээл зүтгэл хэрэглэгдэхгүй бол ямар ашигтай вэ гээд бодоод үзээрэй. Энэ дэлхийн ихэнх агуу амжилтыг мөнхийн амьдралын өнцгөөс харвал дэндүү өчүүхэн үнэ цэнтэй.

Харин нөгөө талд, Бурханы үгийг гүн гүнзгий мэдэх нь мөнхийн утга учир, үнэ цэнтэй билээ. Энэ дэлхий дээр Библиээс сурсан зүйл маань мөнхийн амьдралд хийх хөрөнгө оруулалт юм. Учир нь Библи мөнхийн оронд ч байх болно. Есүс "Тэнгэр дэлхий уставч миний үг устахгүй" гэж хэлсэн. Дуулал номд "Эзээн, Таны үг тэнгэрт мөнхөд тогтжээ" гэж бичигдсэн. Библиээс цээжилсэн эшлэл бүхэн минь, судалсан бүлэг болгон минь, сурсан хичээлүүд маань ирээдүйн амьдралд үр ашгаа өгнө.

Мөнхийн улсад хүн бүхэн адил байна гэдэг үзэл Библийн сургаал биш. Мөхөгсдийн зарим нь хатуу, зарим нь хөнгөн шийтгүүлэхийн адил, аврагдагсдын шагнал хоорондоо ялгаатай байна гэж Бурханы үгэнд заадаг.

Мөнхийн улсад хүн бүхэн аз жаргалтай байх хэдий ч зарим нь тэнгэрийн яруу алдрыг бусдаас илүү мэдэрнэ. Үнэндээ, Эзэн Есүсийг гэх сэтгэл маань Бурханы үгээр Түүнийг хэр их таньж мэдсэнээс минь хамаардаг. Мөнхийн улсад хүн бүхний аяга дүүрэн байх хэдий ч зарим нь том, зарим нь жижиг байна.

Христитгэгч бид заримдаа сайн ажилтай байхын төлөө эсвэл бизнесийн үйл ажиллагаа явуулахын тулд энэ ертөнцийн мэдлэгээс суралцах зайлшгүй шаардлага гардаг. Үүний улмаас зарим нь их сургуульд сурч, зарим нь мэргэжлийн сургалтад суудаг. Гэхдээ ийм төрлийн боловсрол нь амьдралын чухал зүйлс биш гэдгийг үргэлж санаж явах хэрэгтэй. Энэ нь зөвхөн дээш өгсөх гишгүүр чулуу, амин зуулгаа залгуулах хэрэгсэл болой. Мөн Христийг таньж мэдэх, бусдад таниулах үндсэн зорилгын минь туслах хэрэгсэл билээ. Боловсрол олж авахыг гол зорилгоо болгоод Бурханы мөнх үгийг огоорвол буруу. Хожмын тэр өдөр, боловсролыг тэргүүнд тавьсан зам хэчнээн мунхаг болох нь илэрхий болно.

Энэ бүхнийг бодоод үзвэл амьдралд ямар мэдлэгийг чухалчлах ёстой вэ гэдэг нь тодорхой. Хэрэв бид тэнгэрт очихдоо бүрэн мэдлэгт хүрэхгүй бөгөөд энэ дэлхийд сурсан зүйлээ мөнхийн улс уруу авч орох юм бол ирээдүйн

амьдралдаа юу бэлдэх ёстой вэ гэдгээ бодож үзэх хэрэгтэй. Мөнхийн улсад хэрэг болохгүй дэлхийн мэдлэгт шунахаас өөрсдийгөө сэргийлье. Мөн их сургуулийн эрдмийн зэргийг хэтрүүлэн чухалчлахгүй байя. Энэ нь Эзэнд үр нөлөөтэй үйлчлэх багаж хэрэгсэл төдий. Гагцхүү Библи л амь амьдралаа зориулан байж сурч мэдэх ёстой зүйл мөн. Библийг мэдсэнээр түүний Зохиогчийг бид улам бүр таньж мэднэ.

Мөнхийн улсад сурах үйл явц байна. Бид тэнд үргэлжлүүлэн суралцана. Тэрхүү сургалт маань өнөөдөр Библийг хэр сурснаас минь шууд хамаарна.

## ИРЭЭДҮЙГЭЭ ТА СОНГОНО

Ирээдүйгээ та өөрөө шийддэг гэвэл итгэх үү? Та ямар амьдралыг хүснэ тэр л амьдрал танд ирнэ. Та ямар нэг ажил мэргэжил, амжилтыг үнэн голоосоо хүсвэл түүндээ гарцаагүй хүрнэ. Энэ бол маш чухал нууц бөгөөд энэ тухай илүү сайн мэдэх хэрэгтэй. Та өөрөө маргаашийнхаа түлхүүрийг атгадаг.

Бурхан нэг шөнө Соломонд үзэгдэж "Гуйсан зүйлийг чинь өгье" гэж хэлсэн. Соломон мэргэн ухаан, мэдлэгийг гуйхад Бурхан хүслийг нь биелүүлсэн. Дээр нь нэмээд баялаг, эд хөрөнгө, хүндлэл, ялалт, урт удаан амьдралыг хайрласан.

"Гуй би чамд өгье" гэж Бурхан хүн болгонд хэлдэг. Та юуг гуйна түүнийгээ л авах болно.

Лорд Розбери залуудаа гурван зүйлийг чин сэтгэлээсээ хүсжээ. Үүнд:

1. Дербийг ялах
2. Баян хүний охинтой гэрлэх
3. Ерөнхий сайд болох.

Лорд Розбери энэ гурван хүслээ бүгдийг нь авсан болохыг түүх гэрчилдэг.

Олон жилийн өмнө нэгэн залуу Чикаго дахь гэртээ Дуулал 145:19 дэх амлалтыг бариад өвдөг сөгдөн залбирч дараах зүйлсийг Эзэнээс чин сэтгэлээсээ гуйжээ:

1. Библийн ихэнх хэсгийг цээжлэх
2. Номлол бүхий товхимол бичиж түүнийгээ олноор тараах.
3. Христийн зарц нарт товхимлуудаа үнэгүй өгөх.
4. Сайнмэдээг тунхаглаж, Бурханы үгийг номлох.
5. Итгэгчдийг барьж босгох сүнслэг өгүүлэл, нийтлэл бичих.

Том Олсон Библийг цээжээрээ сайн мэддэг байсан бөгөөд түүний сайнмэдээний номлол, Библийн сургаал олон хүнийг ерөөж, сэтгүүлийн өгүүллэг нийтлэлүүдийг нь хүмүүс өргөнөөр уншиж, жижиг товхимлууд нь маш олон хүний гарт хүрснийг түүнийг мэддэг болгон гэрчилнэ. Залуу хүн болгонд энэ зарчим хүчинтэй. Тэдний өмнө ирээдүй хоосон цаас мэт дурайж байна. Тэд ямар сонголт хийнэ, цаасан дээр тэр нь бичигдэнэ.

*Тэгэхээр хүсэх зүйлдээ болгоомжтой хандаарай.* Дэндүү олон зүйл таны сонголтаас хамаардаг. Нэгэнт сонгосон бол эргэж буцна гэж байдаггүй.

Улайссан зуухнаас урсах шингэн төмөр ямар ч хэлбэрт хувирах боломжтой. Гэхдээ нэгэнт хэлбэрээ олоод хөрчих юм бол яаж ч нүдээд хэлбэр нь өөрчлөгдөхгүй. Залуу хүмүүст сонголт хийх асар их боломж байдаг. Хэрэв энэ их



боломжийг ухаарах аваас хожмын өдөр амаа барьж халаглах хүн цөөхөн гарахсан.

Сайн дураараа сонголт хийсэн хүн бүр сонголтынхоо үр дүнг л амсана. Ямар нэг аз эз, тохиолдлын үр дагавар гэж бодох хэрэггүй. Таны амьдрал таны сонголт бөгөөд гаргасан шийдвэр болгоны чинь үр дүн билээ.

Залуучууд аа, та бүхний өмнө асар их нөөц боломж, олон сонголт байна. Та нар хэн ч болох боломжтой. Гэхдээ үнэхээр утга учиртай, үнэ цэнтэй сонголт хийх нь чухал юм шүү! *Өнөөдөр Бурхан чамаас "Амьдралаас чи юу хүсэж байна?" гэж асуувал чи юу хэлэх вэ? Сайн сонс. ТЭР ӨНӨӨДӨР ЧАМААС ЯГ ИНГЭЖ АСУУЖ БАЙНА.*

## ХҮСЭЛ ЗОРИЛГО ЧИНЬ ҮНЭХЭЭР ЗӨВ ҮҮ?

Амьдралынхаа хүсэл зорилгыг хэрхэн тодорхойлбол зөв бэ? Таван минутын дараа нас барна гэж бодвол юу танд хамгийн үнэ цэнтэй санагдах вэ? Цаг хугацаа, авьяас чадвар, нөөц боломж, хөрөнгө мөнгөө юу руу хөрөнгө оруулбал хамгийн зөв бэ?

Баян болох зорилго нь христитгэгч хүнд тохирохгүйг та хүлээн зөвшөөрөх үү?

1. Эзэн Есүс үүнийг хориглосон (Мт 6:19) болохоор энэ нь садар самуун, аллага адил буруу.

2. Материаллаг эд хөрөнгө нь сүнслэг зүйлст саад учруулдаг (Мк 10:23, 24).

3. Эд баялаг хуурамч (Мк 4:19). Эд баялаг бодит мэт харагдавч маш хурдан бөгөөд гэнэтхэн алга болдог.

4. Бидний үлгэр дуурайл Эзэн Есүс Өөрөө ядуу байсан (2Ко 8:9). Ямар ч зарц эзнээсээ илүү байдаггүй гэж Есүс байнга хэлж байлаа (Мт 10:24, 25).

5. Эд баялгийг мөнхийн улс уруу авч явах боломжгүй (2Ко 4:18).

6. Энэ ертөнцөд маш олон хүн ядуу, асар их хэрэгцээтэй байгааг харсаар байж өөртөө эд баялаг хуримтлуулж суух нь христитгэгч хүний ёс зүйд үл нийцнэ.

Хэдэн жилийн өмнө Онтариагийн сонинд дараах мэдээ нийтлэгдсэн: "Онтариа мужийн Пэрт дүүргийн хамгийн баян хүн Жон Ливингстоун нас барлаа. Түүний хөрөнгө таван зуун мянган доллароор үнэлэгдсэн. Түүнээс гадна тэрээр өөрийнхөө амь насыг таван зуун мянган доллароор даатгуулжээ. Тэрээр Шотландын алдарт илгээлтийн эзэн, судлаач Давид Ливингстоуны ах байлаа."

"Ах дүү хоёр Шотландад байхдаа тус бүрийн сонголтыг хийжээ. Жон хөрөнгө чинээтэй болохоор Канадыг зорьсон. Харин Давид амьдралаа Аврагч Эзэн Есүс Христэд өргөж, хар арьстнуудад сайнмэдээ хүргэхийн тулд Африкийн бөглүү нутаг уруу явсан. Энэ ертөнцийн нүдээр Жоны шийдвэр ухаалаг, Давидынх мунхаг харагдана. Гэвч энэ ертөнц тийм ч алсыг хардаггүй ажээ. Жоны бизнес амжилтад хүрч, түүнийг асар их хөрөнгөтэй болгосон. Давид харин амьдралаа Африкт зориулж тэндээ нас барсан. Гэвч тавь жаран жилийн дараа тэдний амьдралын үр дүнг дүгнээд харахад Жоны нэр бараг мартагдсан бол Давид Ливингстоуных сайнмэдээ дэлхийн хаана ч хүрсэн дурсагдсаар байна." (Ч. Э. Татэм)

Гэхдээ эд хөрөнгөний хойноос хөөцөлдөх нь хүмүүсийн сонирхдог цорын ганц зүйл биш. Хүмүүсийн амьдралаа зориулдаг өөр нэгэн хүсэл зорилго бол нэр төр. Хэн нэгэн

болж, нэр нөлөө олж, алдар хүндтэй болохын төлөө олон хүн амь амьдралаа зориулдаг.

Харин зарим нь ажил бизнесийн амжилтыг хүсдэг. Түүнийхээ төлөө хамаг чадлаараа хичээн зүтгэдэг. Тэдний шүтээн нь арилжаа наймаа, шинжлэх ухаан. Тэд амжилтын төлөө улайран тэмцдэг. Гэтэл Бурханы дуу хоолой "Чи өөртөө агуу зүйлсийг хайж байна уу? Бүү хай" (Иер 45:5) хэмээн дуудаж байна.

Зарим хүн спортын талбарт онцгойрохыг хүсдэг. Тэд хатуу сахилга бат дор өөрсдийгөө сургаж, амжилтад хүрэхийн тулд ямар ч золиосыг баяр хөөртэйгөөр гаргадаг. Тэмцээн болох үед тэд шагналын төлөө бүхий л хүчээ шавхан дайчилна. Гэтэл Ариун Бичвэрт Бурхан "хүний хөлд баярладаггүй" (Дуу 147:10) гэж тунхагласан. Бурхан спортын шүтэн бишрэгч биш. Яагаад гэвэл биеийн дасгал сургуулилт нь зөвхөн энэ амьдралд хэрэгтэйг Тэр мэднэ. "Биеийн дасгал нь өчүүхэн тустай. Харин одоогийн болон ирэх амийн төлөөх амлалт бүхий итгэл сүсэг нь бүх зүйлд тустай." (1Тм 4:8)

Зарим хүн гүн ухаан, түүх, хөгжим гэх мэт тодорхой нэгэн салбарт асар их мэдлэг хуримтлуулж түүгээрээ олонд хүндлэгдэхийг хүсдэг. Мөнхийн улсад хэрэг болохгүй

мэдлэгийг хуримтлуулж түүндээ мэргэжилтэн болох нь христитгэгч хүнд зохицохгүй.

Зарим хүн бусдын сайн сайхны төлөө амьдралаа зориулж, нийгмийг сайжруулахын тулд улс төрд оролцож, эргэн тойрноо илүү дээр болгохыг амьдралын зорилгоо болгодог. Эхэнд ярьсан хэдийг бодвол энэ төрлийн хүмүүс дээр юм шиг харагдавч тэдний зорилго ч гэсэн учир дутагдалтай. Хүнд тусалж, асуудлуудыг нь шийдэж өгөхийн тулд эхлээд хүний мөн чанарыг өөрчлөх хэрэгтэй. Гэвч сайн үйлсийн ямар ч ажил хүний мөн чанарыг өөрчилж чадахгүй. Гагцхүү сайнмэдээнд л хүн төрөлхтний асуудлын шийдэл, хариулт байдаг. Жинхэнэ сайхан сэтгэлтэй хүн Эзэн Есүс Христийг л хүмүүст танилцуулна.

Сая бид хүмүүсийн амь амьдралаа зориулдаг зарим хүсэл зорилгыг авч үзэж ярилцлаа. Эдгээр нь нэгт утга учиргүй, хоёрт цагийн шалгуурыг давдаггүй учраас хүний амьдралын хамаг хүчин чармайлтыг хүртэх зохисгүй зорилгууд юм. Эдгээрийн үнэ цэнэ нь зөвхөн энэ амьдралаар хязгаарлагдана. Гэтэл христитгэгч хүн хоёр ертөнцөд амьдардаг билээ. Тиймээс христитгэгч бид хоёр ертөнцийн алсын хараатай байх ёстой.

"Хоёр ертөнцийг боддоггүй хүн амьдралын жинхэнэ утга учрыг хэзээ ч олохгүй. Нэг дэх ертөнц нь одоогийн энэ

амьдрал. Хоёр дахь нь ирээдүйн амьдрал. Хоёр дахь амьдралыг бодох нь зөвхөн настай хүмүүсийн ажил гэж үү? Залуусаас ч гэсэн үл итгэлээс амьдралаа аварч, явцуу хувиа хичээсэн бодлоо гэж, энэ дэлхий дээр амьдарч байхдаа хоёр ертөнцийн тухай боддог тийм хүмүүс болж гарч ирээсэй гэж би хүсэж байна. Хоёр ертөнцийн нэг нь богино, нөгөө нь эцэс төгсгөлгүй. Хоёр ертөнцийн тухай бодох нь ямар ач тустай юм бэ гэж та асуух байх. Үүнийг бодсоноор хүн зуурдын зүйлийн төлөө амьдрах уу, мөнхийн зүйлийн төлөө амьдрах уу гэдгээ шийддэг. Өнөөдрийн үйлс маань мөнхийн амьдралд нөлөө үзүүлж чаддагийг ухаардаг. Үүнийг олж харах хүртлээ би амьдралын асуудлуудтай зоримгоор нүүр тулдаггүй байлаа." (С. И. Скофилд)

Виллиям Келли бол 19 дүгээр зууны төгсгөлд Их Британид Бурханы төлөө эрдэм мэдлэг, сүнслэг байдлаараа том нөлөө үзүүлсэн Библийн эрдэмтэн байлаа. Тэрээр Дублин хотын Тринити коллежид хамаатныхаа хүүхдийг бэлтгэж байгаад тэндхийн профессоруудын анхааралд өртжээ. Тэд түүнийг их сургуульд нь ажиллаж нэр хүндтэй болохыг ятгав. Ноён Келли нэг их сонирхохгүй байгааг нь тэд гайхаад "Ноён Келли та ертөнцөд нэр алдартай хүн болохыг хүсэхгүй байгаа юм уу?" гэж асуужээ. Келли

хариуд нь "Ноёд оо, та бүхэн аль ертөнцийг яриад байна?" гэж асуусан гэдэг. Би үүнийг л яриад байна. Амьдралд ямар хүсэл зорилготой байх тухай бодохдоо "Аль ертөнцөд вэ?" гэж өөрөөсөө асууцгаая. *Энэ өнцгөөс харвал таны хүсэл зорилго утга учиртай байж чадах уу?*

## АМЬДРАЛЫН ЗАЙЛШГҮЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Ирээдүйн тухай ухаалгаар бодъё гэвэл гурван зүйлийг зайлшгүй авч үзэх ёстой:

1. Бурханы өмнө хүлээсэн үүрэг
2. Бусдын өмнө хүлээсэн үүрэг
3. Өөрийнхөө өмнө хүлээсэн үүрэг

Энэ гурван үүргийг биелүүлэхгүйгээр хүний амьдрал хэзээ ч амжилттай байж чадахгүй.

### Бурхан

Бурхан нэгт байх ёстой. Тэр бидний бүтээгч. Зөвхөн үүнийг бодоход л Тэр бидний хувиршгүй итгэл сэтгэл, үнэнч үйлчлэлийг хүртэх зохистой Нэгэн гэдэг нь тодорхой. Гэтэл тэр агуу Бүтээгч бидний Аврагч болсон. Тиймээс бидний зайлшгүй хүлээн зөвшөөрөх мөнхийн үнэнүүд гэж бий. Үүнд:

1. Бурхан агуу өршөөл нигүүлслийнхээ улмаас цорын ганц Хүүгээ илгээж, миний оронд үхүүлсэн.

2. Эзэн Есүс миний төлөө сайн дураараа тэнгэрийн цог жавхлангаа орхиж, хог новш, ичгүүр гутамшгаар дүүрэн энэ орчлонд ирсэн.



3. Тэр миний сүнсийг аврахын тулд зовлон эдэлж, цусаа урсгаж, үхсэн.

4. Үхэлд хүртэл дуулгавартай байсан тэр Нэгэн жирийн хүн биш, харин энэ орчлон ертөнцийг бүтээсэн Бүтээгч Бурхан билээ.

5. Би түүний дайсан байсан хэдий ч Тэр миний төлөө үхсэн.

6. Миний нүглийн шийтгэлийг төлөхийн тулд Түүний эдэлсэн зовлон нь ямар ч хүн ойлгож ухаарч чадахааргүй их.

7. Тэр намайг нүглийн боолын хар захаас худалдаж авахын тулд цусаа урсгах хэмжээний үнэ цэнтэйд намайг тооцдог.

8. Тэр миний Эзэн, миний Хаан байхын тулд үхсэн.

Христитгэгчид энэ үнэнүүдийг байнга сонссоор байгаад дөжрөх аюултай. Хэрэв энэ үнэнүүд сүнс сэтгэлд минь нэвчин орвоос бид өөрийн эрхгүй Бурханд бууж өгч,

*Бүгдийг Тэр миний төлөө хийжээ*

*Бүгдийг Тэр миний төлөө хийжээ*

*Бүх сайнаа зориулахаас өөр би яах билээ*

*Бүрэн Түүний төлөө зүтгэхгүй би хаачих билээ*

*Бүгдийг Тэр миний төлөө хийжээ (Бетти Даасванд)*

хэмээн дуу алдах нь дамжиггүй.

Христ намайг цусаараа худалдаж авсан нь үнэн юм бол би өөрийнх биш, зөвхөн Түүнийх гэдэг нь ойлгомжтой. Тэгэхээр элч Паулын хэлсэн үг үнэн юм: "Христийн хайр биднийг албаддаг. Учир нь Нэг нь бүгдийн төлөө үхсэн тул бүгд үхсэн гэж бид ятгагдсан. Тэрээр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой." (2Ко 5:14,15)

Тиймээс өөрсдийн төлөө биш Христийн төлөө амьдарцгаая. Ч. Т. Стадд үүнээс өөр дүгнэлт олж харж чадаагүй байна: "Есүс Христ миний төлөө үхсэнийг мэддэг байсан. Гэхдээ миний төлөө үхсэнээрээ намайг өмчилдөг болсныг би огт ухаарч байсангүй. Золилт гэдэг нь үнийг нь төлөөд худалдаж авахыг хэлдэг. Тэгэхээр би Түүний өмч гэсэн үг. Хэрэв би өрөөлийн юмыг өөртөө хадгалбал хулгайчаас ялгаа юун. Эсвэл бүхнээ Бурханд өргөх сонголт миний өмнө гарч ирнэ. Есүс Христ миний өмнөөс үхсэнийг үнэн голоосоо ухаарах үедээ Түүний төлөө бүхнээ өргөх нь хэцүү санагдахаа больсон."

Исаак Уотс ч бас үүнийг ойлгодог байжээ. Үүнийг тэрээр зохиосон дуундаа өгүүлжээ. Бид тэр дууг сайн мэддэг боловч утгыг нь амьдралдаа барагтаа бол хэрэгжүүлдэггүй.

*Бүх хорвоо минийх байлаа гээд ч  
Танд өргөхөд дэндүү өчүүхэн  
Ийм гайхамшигт агуу их хайранд  
Өөрийгөө өгсөн ч бас л багадна.*

Цинцендорф гүн: "Аврагч Эзэндээ хамгийн хайртай зүйлээ өргөхгүй л юм бол би Түүнд яаж зохистой нэгэн байж чадах юм бэ?" гэж хэлсэн байдаг.

Угандагийн Пилкинтон: "Хэрэв Тэр Хаан юм бол бүхнийг минь авах эрхтэй" гэж хүлээн зөвшөөрсөн.

Хэдэн жилийн өмнө илгээлтийн эзэн Т.Э.Уилсон Анголын нутгийн иргэдэд номлож байжээ. Тэгэхэд сонсогчдын дунд том биетэй нэгэн залууг өрөвдөлтэй харцтай хүү байнга дагаж явахыг тэр ажиглажээ. Том эрийг хаашаа л хөдөлнө хүү айж түгшсэн байдалтай араас нь явж байлаа. Номлол дууссаны дараа тэр залуу боолтойгоо хамт явж байсныг Уилсон мэдэж авав. Тэр даруй Уилсон хүүг худалдаж авахын тулд эзэнтэй нь наймаацжээ. Эзэн нь маш өндөр үнэ хэлсэн боловч илгээлтийн эзэн маань нөхцөлийг зөвшөөрч хүүг худалдаж авав.

Христитгэгч залуу худалдаж авсан боолтойгоо гэртээ ирэхэд хүү өмнөх эзнээсээ айдаг шиг айж чичирсээр байхыг анзаарлаа. Гэртээ ирснийхээ дараа Уилсон хүүг хажуудаа

суулган "Хүү минь, би өнөөдөр чамайг худалдаж авсан. Одоо чи миний өмч. Гэхдээ чи өнөөдрөөс эхлэн эрх чөлөөтэй. Дуртай юмаа хийж болно. Чи ширэнгэн ой уруугаа буцаад өөрийнхөнтэйгөө амьдарч болно. Эсвэл манайд үлдээд гэр бүлийн минь гишүүн болж ч болно" гэжээ.

Илгээлтийн эзэн худлаа яриагүйг хүү ойлгомгоцгоо нүдэндээ нулимстайгаар "Ноён Уилсон, би үүрд таны боол байя" гэж хэлжээ.

Тэр үүнээс өөр ямар ухаалаг хариу барих байсан юм бэ? Бидний нөхцөл ч гэсэн адилхан. Бид Эзэн Есүст хандан "Би үүрд таны боол байя. Миний гар хөл, дуу хоолой бүгд Таных. Та миний төлөө үхсэн. Тиймээс би Таны төлөө амьдарна" гэж хэлэх ёстой бус уу?

Бурханы өршөөл нигүүлсэл биднийг Түүний өмнө үүрэгтэй болгодог. Түүний сайхан сэтгэлд бүх амьдралаа юу ч үлдээхгүй өргөх нь зүй ёсны хариу мөн (Ром 12:1, 2).

### **Таны хөрш**

Бидний хүлээсэн хоёр дахь үүрэг хариуцлага нь хүмүүсийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага юм. Христитгэл нь амин хувиа хичээх үзлийн эсрэг. Паул, грекүүд болон зэрлэгүүд, мэргэн болон мунхгуудын аль алинд нь би

үйлчлэх ёстой гэж хэлсэн шиг, христитгэгчид тийм л сэтгэлийг өвөртөлж явах учиртай (Ром 1:14). "Би сайнмэдээг эс тунхаглаваас золгүй еэ!" (1Ко 9:16) гэх сэтгэл, мөн сүнснүүдийн төлөөх шатсан зүрх христитгэгчийг зөв итгэл дээр байлгадаг.

Үнэн сүсэгт итгэгчид амьдралаа төлөвлөхдөө доорх зүйлсийг заавал бодож үзэх хэрэгтэй. Үүнд.

1. Ертөнц мөхөл рүүгээ явж байна.

*Өрөвдөлтэй сүнснүүд мянга мянгаараа*

*Өдөр бүр мөхөл рүүгээ явж байна*

*Хөөрхий тэд ял буруутгал дотроо*

*Христгүйгээр нэг нэгээрээ үхэж байна*

2. Аврагдсан биднийг мөнхийн улсад юутай ч зүйрлэшгүй баяр хөөр хүлээж байхад, Христгүй үхэж буй хүмүүсийг мөнхийн зовлонгийн аймшигт тарчлал угтах болно. Итгэгч бүр мөнхийн зовлонг бодож үзэх ёстой. Үүрд мөнхийн, эргэж буцахгүй түнэр харанхуй, аймшигт тарчлал ямар болохыг төсөөлөх хэрэгтэй. Хамаатан садан, найз нөхөд, эргэн тойрны хөршүүд минь аврагдахгүй бол хэзээ нэгэн цагт тэнд очно гэдгийг тунгаах учиртай. Ингэж бодсоны дараа нэгэн хэвийн урсгалаараа явах итгэгч хаана ч байхгүй.

3. Сайнмэдээ худал бол түүнийг тэр чигт нь таягдан хаявал таарна. Харин үнэн бол дэлхийн өнцөг булан бүрд тунхаглах ёстой. Хорт хавдрын эмчилгээг мэдсэн хэр нь хэнд ч хэлэхгүй бол алуурчнаас ялгаа юун. Түүн шиг, хүмүүний авралын замыг мэдсээр байж тэр тухай бусдад ярихгүй бол сүнсний алуурчинтай адилхан.

*Бурханаас өгөгдсөн мэргэн ухаанаар*

*Бусдын сүнсэнд гэрэл тусгах уу?*

*Харин цөмөөрөө дэмий суусаар*

*Харанхуй чигт нь тэднийг үлдээх үү?*

4. Энэ үеийн хүмүүст энэ үеийн христитгэгчид л сайнмэдээг хүргэж чадна. Бидний үүрэг бусдад шилжихгүй.

5. Агуу захирамжийн (Мт 28:19,20) төлөө юу хийснээ бид тайлагнах болно. Мөнхийн улсад орох үед өмссөн хувцас минь мөхөгсдийн цусаар толботсон байх уу?

6. Бидний уулзсан хүн бүр Аврагчийн титэмд онцгой нэгэн үнэт чулуу болох боломжтой. Тиймээс Эзэний төлөө тэднийг хайрлах нь бидний үүрэг.

Бид энэ үнэнүүдтэй шударга бөгөөд зоригтойгоор нүүр тулах ёстой. Эс бөгөөс энэ амьдралаа жинхэнэ утга учиртай өнгөрүүлж чадахгүй.

## Та өөрөө

Эцэст нь бидний амьдралын төлөвлөгөө өөрсдийн маань ашиг тусыг мөн харгалзан үзэх ёстой. Өнгөц харвал энэ нь хувиа хичээсэн үзэл шиг харагдах боловч тийм биш. Яагаад гэвэл Бурхан бидэнд хамгийн сайныг хүсдэг бөгөөд бидэнд зориулж хайраараа бэлдсэн төлөвлөгөө нь бидний сайн сайхны төлөө юм.

Би яаж амьдарвал дэлхий дээрх болон мөнхийн улс дахь амьдралаа хоёуланг нь ашиг тустай байлгаж чадах вэ? Залуу итгэгчид доор бичсэнийг нухацтай бодох хэрэгтэй. Үүнд:

1. Хүний сүнс аврагдавч энэ амьдрал нь сүйрэх боломжтой.

2. Энэ амьдрал төгсгөл биш. Харин мөнхийн амьдралд хийх хөрөнгө оруулалт юм. "Энэ амьдрал нь мөнхийн хаанчлалд бэлтгэх сургалтын хугацаа юм."

3. Үхсэний чинь дараа ч гэсэн үйл хэрэг чинь үргэлжилдэг тийм амьдралаар амьдрах боломжтой. "Хүмүүний үүрэг болбоос үхсэнийх нь дараа ч үргэлжилсээр байх нэр төртэй ажлыг хийх явдал мөн." (Ф. В. Борэм)

4. Хэзээ нэг өдөр бид Христийн шүүх суудлын өмнө зогсох болно. Тэр үед юу өндрөөр үнэлэгдэх вэ? Зөвхөн Бурханы төлөө амьдарсан амьдрал л өндрөөр үнэлэгдэнэ.

5. Та тэр өдөр гар хоосон зогсож байх вий.

*Хайрт Аврагчтайгаа уулзах өдөр*

*Хоосон гартай зогсож байх уу?*

*Хөлд нь тавих нэг ч үйлчлэлгүй*

*Хийсэн ажилгүй зогсож байх уу?*

*Хүндэт Аврагчтайгаа уулзах өдөр*

*Хэлэх үггүй зогсож байх уу?*

*Христийг таниулсан нэг ч хүнгүй*

*Хийсэн ажилгүй зогсож байх уу?*

(Ч.К. Лютер)

6. Эзэн "Сайн байна" гэж хэлээгүй л бол ямар ч ажил сайн биш. "Явах ёстой замаараа явалгүй өөр зам дээр завгүй байх хооронд минь үнэнийг хайсан нэгэн тэр замаар өнгөрч бидэнтэй таарахгүй бол ямар харамсмаар юм бэ! Өдөр өнгөрч бүхнийг эргээд харахад явах ёстой зам дээр минь, биднийг аварсан Эзэн зогсоод "Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун" хэмээн үнэнийг хайгч сүнсэнд хэлэх нэгнийг хайсан боловч бид тэнд байгаагүй бол юутай халагламаар хэрэг вэ!" (Эми Кармайкл)

Энэ бүхнийг хормын төдийд бодож үзэхэд Бурханы хүслийг нэгт тавьснаар л одоогийн амьдрал ба мөнхийн амьдралын аль алинд нь бид өөрсдөдөө хамгийн ашигтайгаар амьдарч чадах нь ээ.



Одоо тэгвэл бүгдээрээ хэсэг зуур завсарлаад өөрсдийн хүсэл зорилгыг эргэцүүлж дараах асуултуудыг өөрсдөөсөө асууцгаая.

1. Бидний хүсэл зорилго Бурханы өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай минь уялдаж байна уу?

2. Бидний хүсэл зорилго хүмүүсийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг минь биелүүлж байна уу?

3. Бидний хүсэл зорилго одоогийн болон мөнхийн амьдралд минь надад ашиг тустай юу?

Хэрэв бидний хүсэл зорилго энэ гурван асуултад үгүй гэж хариулбал үнэ цэнгүй бөгөөд тийм хүсэл зорилгыг таягдан хаях хэрэгтэй.

## АМЬДРАЛЫН ХАМГИЙН ЧУХАЛ ҮҮРЭГ

Итгэгч бүр Бурханы өмнө, хүмүүсийн өмнө, өөрийнхөө өмнө үүрэг хариуцлага хүлээдэг гэдгийг өмнөх бүлэгт авч үзлээ. Бурхан биднийг бүтээсэн бөгөөд зольж аварсан учраас бид Бурханы өмнө үүрэг хариуцлагатай. Христгүй хүмүүс мөнхийн зовлон уруу явж байгаа учраас бид хөршүүдийнхээ өмнө үүрэг хариуцлагатай. Мөн бид хожим Христийн шүүх суудлын өмнө зогсож бүх амьдралаа тайлагнах ёстой учраас өөрийнхөө өмнө үүрэг хариуцлагатай.

Тэгвэл христитгэгч хүн энэ гурван үүрэг хариуцлагыг хэрхэн биелүүлэх вэ? Хүн зөвхөн өөрийнхөө төлөө амьдарвал энэ амьдралын утга учрыг алдахаас гадна дараагийн амьдралд гар хоосон орох болно. Энэ нь тэгээд өөрийнхөө ашиг тусын төлөө явах мөн гэж үү?

Хэрэв итгэгч хүн хөршийнхөө сайн сайхны төлөө явахдаа сайнмэдээг орхигдуулбал үнэндээ хөршдөө сайныг хийж байгаа хэрэг огт биш. Яагаад гэвэл хүмүүний цорын ганц амин хэрэгцээ бол Христ юм. Хүн Христийг хүлээн аваагүй л бол үүрд мөхнө. Харин хүн бүх амьдралаа Эзэнд өргөвөл ямар ч алдаа гарахгүй. Учир нь Бурханыг хайрладаг хүн сайнмэдээгээр дамжуулан хүн төрөлхтөнд тусалж, өөртөө ч ашиг тустай амьдардаг. Бурханд амьдралаа

зориулсан хүн энэ амьдралдаа ашиг тустай амьдрахаас гадна ирээдүйд шагнал хураадаг.

Амжилттай христитгэлт амьдралын нууц нь тэгэхээр бүхнээ Бурханд өргөх амьдрал ажээ.

Үүний тулд бид өөрсдийнхөө амьдралд юу хамгийн чухал болохыг мэдэхгүй гэдгээ юун түрүүнд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Иеремиа үүнийг ийн ярьсан байдаг: "Эзэн минь, замаа хүн өөрөө хардаггүйг би мэднэ. Алхмаа хүн өөрөө чиглүүлдэггүйг ч бас мэднэ." (Иер 10:23)

Мөн Бурхан бидний амьдралд хамгийн сайн төлөвлөгөөг бэлдсэн гэж итгэх хэрэгтэй. Бид тэр төлөвлөгөөг хүсэх аваас Бурхан амьдралд маань хамгийн сайныгаа өгнө. Хүсэхгүй аваас хамгийн сайныг нь биш хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх сайныг нь үзэх биз ээ.

Үнэхээр үүнд итгэвээс хүний амьдралын хамгийн агуу үүрэг хариуцлага нь амьдралаа Бурханд өргөх явдал гэдгийг бид ухаарна. Өөрийгөө өргөх гэдэг нь сүнс, сэтгэл, бие гээд бүхнээ Эзэнд өгөхийг хэлж байна. Мөн бүх эрхтнээ, байгаа бүхнээ Эзэнд зориулж, Эзэний төлөө өөрийн хүслээсээ ямар ч болзолгүйгээр татгалзаж, Эзэнд бүрэн бууж өгнө гэсэн үг.

Бэтти Стэм итгэлийнхээ төлөө амиа алдахаас есөн жилийн өмнө ийм зориулалтыг гаргахаар эргэлт буцалтгүй шийдсэн байна. Тэрээр Библи дээрээ "Эзэн минь, би өөрийн

бүх зорилго, хүсэл тэмүүлэл, төлөвлөгөө, итгэл найдвараасаа татгалзаж, амьдралд минь зориулсан Таны хүслийг хүлээн авч байна. Би өөрийгөө, өөрийнхөө амьдралыг, бүхнээ Танд өргөө. Энэ бүхэн үүрд Таных. Найз нөхөд, хайр сэтгэлээ ч Таны мутарт даатгая. Хайртай хүмүүс минь бүгд миний зүрхэнд хоёрт байх болно. Намайг Ариун Сүнсээрээ дүүргэж тамгалаач. Өөрийнхөө хүслийг ямар ч үнээр хамаагүй одоо ба үүрд мөнхөд миний амьдралд гүйцэлдүүлээч. Миний хувьд амьдрах нь Христ, үхэх нь ололт юм" гэж бичсэн байлаа.

Йелийн Их Сургуулийн Бордэн сайнмэдээ хүргэхээр Хятад уруу явж байх замдаа Египетэд тархины менингитээр нас барахаасаа хэдэн жилийн өмнө Бурханд бүхнээ өргөхөөр шийдэж, "Эзэн Есүс ээ, бүх амьдралаа би Танд даатгая. Зүрхнийхээ хаан сэнтийд Таныг залъя. Өөрийнхөө хүслийн дагуу намайг өөрчилж, цэвэрлэж, ашиглаач. Ариун Сүнсээрээ намайг дүүргээч. Тандаа талархъя" хэмээн хэлж байлаа.

Энэ хүмүүсийн залбирал Гетсемани цэцэрлэгийн нам гүмийг эвдэн "Миний хүсэл биш, Таны хүсэл биелэг" гэж хашхирсан Эзэн Есүсийн дуу хоолойн цуурай биш гэж үү?

Бурханы дотор өсөж буй хүн бүр өөрийн хүслээс татгалзаж, түүнийгээ Бурханд өргөн,

Таныг хаашаа яв гэнэ, тийшээ би явъя

Таныг юу хий гэнэ, түүнийг би хийе

Таныг юу хэл гэнэ, түүнийг би хэлье

Таныг хэн бол гэнэ, тийм хүн би больё гэж хэлэх үе заавал ирдэг.

Харин ямар ч болзол тавихгүйгээр ийн бууж өгсний дараа өдөр бүр энэ шийдвэр дээрээ бат зогсох ёстой болно. Бурханд өөрийгөө зориулах шийдвэрээ байнга сахих нь итгэгч хүний амьдрал билээ. Бид Эзэний боол бөгөөд эзнийхээ зааварчилгааг байнга хүлээж байдгаа санаж явбал зохилтой. Мөн амьдралын бүхий л талбарт Христийг Эзэн болгож байх ёстой.

Дараа нь юу болох вэ? Бие махбодод маань агуу өөрчлөлт ирэх үү? Сэтгэл санаанд эрс шинэчлэл гарах уу? Тэнгэрээс залбирлын хариултын гал буух уу?

Ихэнх тохиолдолд гадна талд мэдрэгдэх тэмдэг үзэгдэхгүй. Харин Бурхан тэнгэрт залбирлыг минь сонсож, өргөлийг минь хүлээн авсан гэх итгэлийн баталгаа чимээгүйхэн ирнэ. Бид нүглээ улайн Түүний өмнө ирэхэд Тэр биднийг аварна гэдэгт итгэдэг шигээ, өөрсдийгөө амьд тахил болгон өргөхөд Тэр биднийг хүлээн авна гэдэгт итгэх хэрэгтэй.

Бурханы төлөө шийдвэр гаргасны дараа амьдрал өмнө байснаараа л байна. Түүнээс болоод та сэтгэлээр унаж магад. Өдөр тутмын ажил дэндүү аахар шаахар, ач холбогдолгүй санагдаж ч мэднэ. Гэвч Бурханд амьдралаа өргөсөн бол, таны л явах зам гэж байдаг юм шүү! Та бага зүйл дээр ч гэсэн итгэмжтэй хандвал Бурхан таныг хямрал дундуур дагуулаад аваад гарах болно. Бурхан таныг алхам алхмаар замчилна. Амьдралд тохиолдол гэмээргүй үйл явдал, жижиг жижиг давхцал тохиолдож эхэлнэ. Өөрийнхөөрөө явсан бол хэзээ ч олж үзэхгүй боломжууд гарч ирнэ. Бурханы замчлал зарим тохиолдол дэндүү илэрхий харагдах ч, заримдаа тэгэхгүй. Гэвч хэдэн жил өнгөрсний дараа эргээд харахад, Эзэн үнэхээр замчилжээ гэж хэлэхээс өөр үг олдохгүй.

Эзэнд өөрийгөө өргөх амьдрал нь заримдаа удаан хүлээх замыг туулна. Шаналгаат тэр хүлээлт бидний хийж чадах ганц л зүйл болох үе олон тохионо. Гэвч энэ нь сургалтын чухал хэсэг юм.

Түүнээс гадна, эргэж буцмаар шантармаар үе ч бишгүй тохиолдоно. Нэгэн итгэгч том өрөөнийхөө ханан дээр "Эзэн минь, ямар ч үнээр хамаагүй намайг Өөрийнхөө төлөө байлгаач" гэж бичээд наажээ. Гэвч нэг өдөр тэрээр чимээгүйхэн орж ирээд бичгээ хуулж авлаа. Учир нь гаргах золиос нь дэндүү өндөр байв. Бид золиос гаргахдаа эргэж

буцаж болохгүй. Учир нь "Анжсан дээр гар тавьсан атлаа арагшаа харагч хэн боловч Бурханы хаанчлалд үл тэнцэнэ" (Лк 9:62) гэж Эзэн Есүс айлдсан.

Бурханы төлөө өөрийгөө өргөсөн амьдралд юу ч тохиолдсон эргэж буцаж болохгүй. Борден ийм амьдралыг "Харамсаж, шантарч, эргэж ухрах замгүй амьдрал" гэж тодорхойлсон. Ийм амьдрал заавал шагнуулна. Энэ бүхнийг хувийнхаа амьдралд хэрэгжүүлье. Бурханы өмнө суугаад дараах асуултуудтай зоригтойгоор, шударгаар нүүр тулья.

*Амьдралын хамгийн чухал үүрэг болох Бурханд өөрийгөө зориулах шийдвэрийг та гаргасан уу?*

*Та Бурханы өмч болох энэ амьдралаа өөртөө хадгалахыг хичээж, Бурхантай маргалдсаар байна уу?*

*Таны төлөө үхсэн Аврагчид өгөхөд дэндүү үнэтэй зүйл бий юу?*

*Таны очихыг хүсдэггүй газар байгаа юу?*

*Хэзээ нэг өдөр Бурхан таныг нэр төргүй ажил хийлгэхээр дуудах вий гэж та айдаг уу?*

*Та яг одоо эргэлт буцалтгүйгээр бүх амьдралаа Есүс Христэд өгч чадах уу?*

*ЭЗЭН ЕСҮСТ АМЬДРАЛАА ӨГӨХГҮЙ ГЭДЭГ АЙМШИГГҮЙ ШИЙДВЭРИЙГ ГАРГАХ ГЭЖ БАЙГАА ЮМ БИШ БИЗ ДЭЭ?*

## АЖИЛ МЭРГЭЖИЛ ЮУНД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Христэд бүх амьдралаа өргөх тухай ярихаар "Би тэгээд яаж амьдрах юм бэ?" гэдэг сөргүүлэл заримдаа сонсогддог. Ийм өрөвдөлтэй будилсан асуултыг яаж бодож болох юм бэ? Тэд дараах гурван зүйлийг яриад байдаг:

1. Бид юу ч болж байсан амьдрах хэрэгтэй.
2. Христийн төлөө амьдралаа өргөсөн хүн автоматаар бүтэн цагийн үйлчлэл рүү орж, амин зуулгаа залгуулах ажил хийхээ больдог.
3. Бурханд амьдралаа зориулсан хүн юмаар гачигдана. Харин Бурханд өөрийгөө зориулахгүй сайн ажилтай болчихвол тийм юм болохгүй.

Дээрх асуултыг нэгдүгээр утгаар асуусан бол тэр хүн буруу ойлголттой явдаг нь харагдана. Христитгэгчид амь гарах гэж явдаггүй ээ. Бид Эзэн Есүсийн зарц боол учраас хэзээ, яаж үхэхээ сонгодоггүй юм. Бурхан хүсэж л байвал бид амьдарч л таарна. Тэр болтол юу ч бидний амийг авч одохгүй.

Хоёрдугаар утга ч гэсэн буруу үзэл бодлоос улбаатай. Итгэгч болгон бүтэн цагийн үйлчлэлтэй. Заримынх нь үйлчлэл илгээлтийн талбарт, харин заримынх нь гал тогоонд, зарим нь Африкийн мухар сүсэгт хүмүүст, харин зарим нь АНУ-ын иргэдэд гэрчлэх дуудлагатай.



Дээрх асуултыг гурав дахь утгаар асуусан ч бас л буруу үзэл бодол шингэжээ. Христийн хүсэл сонирхлыг нэгт тавьсан хүний амьдралын хэрэгцээ хангагдана гэдгийг тэд мартсан байна. "Гагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно." (Мт 6:33)

Энэ сэдэв дээр эрүүл зөв үзэл бодолтой болохын тулд христитгэгч хүний амьдралд ажил мэргэжил ямар ач холбогдолтой болохыг авч үзье.

1. Бурхан анхнаасаа хүнийг ажил хийж амьдралаа залгуулаасай гэж хүссэн. "Чи газар шороондоо буцталаа духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ" (Эх 3:19). "Чи зургаан өдөр хөдөлмөрлө" (Гэт 20:9). "Хэн ажил хийхийг үл хүснэ, тэр нь бүү идэг" (2Тс 3:10). Хичээнгүйлэн ажиллана гэдэг ичих зүйл биш. Харин ч Бурханы өгдөг ивээл юм.

2. Хаана ажилд орох, ямар мэргэжилтэй болох тал дээр христитгэгч Эзэний зааврыг эрэлхийлэх ёстой. Яг л илгээлтийн талбар уруу явахдаа Эзэний зааврыг хүлээдэг шиг тодорхой чиглүүлгийг хүлээх хэрэгтэй.

3. Тэгэхээр ажил гэдэг нь сайнмэдээний үйлчлэлтэй эн зэрэгцэхүйц чухал юм. Гол нь тухайн ажлыг сонгоход Бурхан замчилсан байх нь чухал. Гэхдээ Эзэний хүсэлд чин

үнэнчээр бууж өгч, Бурхан хаашаа ч чиглүүлсэн явахад бэлэн болоогүй бол Бурхан замчилсан гэдэгт яаж бүрэн төгс итгэж чадах вэ?

4. Өнөө үед "дэлхийн" ажил, "ариун" ажил гэж ажлуудыг ялгаж ярьдаг болжээ. Энэ нь Библийн сургаал биш. Бурханы алдрын төлөө хийсэн бүх ажил ариун юм. Энэ талаар Г.Кэмбэл Морганы бичсэнийг иш татъя: "Дэлхийн ажил гэсэн нэр томъёог итгэгчдийн амнаас бүр мөсөн зайлуулах хэрэгтэй. Ажилчин нь ариун бол бүх ажил ариун гэж Есүс номлосон. Би хэрүүл маргаан дэгдээх гэж биш, харин хүний амьдралын тухай буруу ойлголтыг засахын тулд үүнийг хэлж байна. Номлол хийдэг эсвэл ямар нэг чухал үүрэг гүйцэтгэдэг байлаа гээд өөрийгөө бусдаас ариун мэт ярих эрх хэнд ч байхгүй. Жирийн засварчин хүн өглөө босоод ажилдаа гарлаа гэж бодъё. Хэрэв тэр засварчин ариун хүн бол ажил нь ч ялгаагүй ариун. Мужаан хүн хэсэг модыг аваад хөрөөдлөө гэж бодъё. Хэрэв тэр мужаан ариун хүн бол хөрөө нь Бурханы ажлыг хийх багаж зэвсэг юм. Бүх ажил ариун ажил мөн. Дараагийн долоо хоногийн турш үүнийг бодон Христийн төлөө ажиллаарай. Та албан өрөөнд ч бай, мужааны цехэд ч бай, гэр орондоо ч бай, хаана ч байсан ийм л сэтгэлээр ажлаа хийх хэрэгтэй."

5. Ямар ажил хийх вэ гэдэг талаар Эзэний заавар хайж байгаа бол Бурхан ер нь төрөлх авьяас чадварынх нь талбарт хүнийг ашигладаг гэдгийг санаарай. Гэхдээ заавал гэсэн үг биш. Нийтлэг тохиолдол ийм байна.

6. Мэдээж хэрэг, Эзэн итгэгч хүнийг хууль бус, ёс суртахуунгүй үйлдэл шаардсан ажил уруу замчлахгүй. Христийг гэрчлэх гэрчлэлийг нь үгүй хийх, ертөнцийн зарчмаар ажиллах тийм ажил мэргэжлийг сонгох хэрэггүй.

7. Амьдралын гол зүйл ажил биш гэдгийг бид байнга бодож явах ёстой. Ажил гэдэг гагцхүү амин зуулга залгуулах үүрэгтэй. Кэри гэдэг алдартай гутал засварчин байлаа. Түүнээс ямар ажил эрхэлдэг талаар нь асуухад "Миний ажил бол сайнмэдээг тунхаглах. Харин зардлаа нөхөхийн тулд би гутал засдаг" гэж хариулжээ.

Өөрийнхөө нэрээр их дэлгүүр нээсэн Жон Ванмэйкирын талаар үүнтэй адил түүх яригддаг. "Тан шиг завгүй хүн яаж бүтэн сайны цуглаанд очих зав гаргадаг юм бэ?" гэж түүнээс асуухад тэрээр "Та юу ярина вэ? Бүтэн сайны цуглаан чинь миний гол ажил шүү дээ. Бусад нь бол дагалдах зүйлс. Тавин таван жилийн өмнө би 'Гагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно' гэсэн Эзэний амлалтаас тас зуурахаар шийдсэн юм" хэмээн хариулжээ.

Бид энэ зарчмыг л баримталж явах ёстой. Нэгт Эзэний хүсэл сонирхол, хоёрт ажил мэргэжил. Бид ажлыг чухалчлаад ирэхээрээ л буруудаж эхэлдэг. Гар бариад бугуй барина гэгчээр ажлаа гэсэн сэтгэл маань Эзэний байр суурийг эзлээд авдаг. Ажлаа чухалчилсан хүн цуглаандаа явахаа больж, Христэд үйлчлэх үйлчлэлээсээ холдож, өөр ашиггүй зүйлсэд цаг заваа зарцуулж эхэлдэг.

Энэ нь аяга шөлөөр ууган хүүгийн эрхээ худалдсантай адил юм. Жовет ийм итгэгчийг "компанийн нэгэн ажилтан төдий" гэж нэрлэсэн. Итгэгч хүн ийм аахар шаахар зүйлтэй зууралдсанаараа амьдралынхаа жинхэнэ утга учрыг гээдэг.

8. Ажил хоёрт байх ёстой гэхээр ажлаа хайнга цалгар хийнэ гэсэн үг биш. Харин ч ажлаа чин сэтгэлээсээ сайн хийх нь Христийг гэрчлэх боломж юм. Бурханы хүүхэд цалин авч байгаа цаг минут болгоноо ажил олгогчдоо бүрэн зориулах ёстой. Ажлын цагаараа сайнмэдээ тараагаад яваад байж болохгүй. Тэр ажлыг ажлаа дууссаныхаа дараа өөрт байгаа цагтаа хийнэ.

Ажил олгогч нар заримдаа хил хязгаараа давж, Эзэний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын маань эсрэг зүйлийг шаарддаг. Олон итгэгчийн хувьд үүнийг тэнцвэртэй авч явах амаргүй байдаг. Гэхдээ хүн Бурханыг хүндэлбэл

Бурхан түүнийг хүндлэх бөгөөд зайлшгүй ажлаа солих болсон ч гуйлга гуйх хэмжээнд аваачихгүй.

9. Бид өөрсдийн амьдралыг үл итгэгчдийн хийж чадах зүйлд зарцуулах хэрэггүй. Эзэн Есүс "Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла" (Лк 9:60) гэж айлдсан. Үхэгсдийг хэн ч оршуулж чадна. Харин Христийн авралын нигүүлслийг биднээс өөр гэрчилж чадах хүн байхгүй. Сайнмэдээг тунхаглах нь зөвхөн бидний үүрэг юм.

10. Эзэн Есүсийн төлөө зарцуулах ёстой цагийг мөнгөний ашиг хонжооны төлөө үрэх ёсгүй. Чуулганд зориулах ёстой цагийг ямар нэг компанийн төлөө зарцуулах ёсгүй.

11. Бид үүргээ итгэмжтэй биелүүлж, Бурханд даруугаар ашиглагдах үед Эзэн үйлчлэлийн маань цар хүрээг тэлдэг. Ингээд Эзэний ажилд зориулах цаг маань улам нэмэгддэг. Гэхдээ тэглээ гээд өдөр тутмын хэрэгцээг минь Бурхан орхигдуулдаггүй. Эсвэл Бурхан биднийг бүх цагаа сайнмэдээний ажил юм уу үгийн үйлчлэлд зориул гэж дуудсан байж болно. Үнэхээр Эзэн ийн чиглүүлж байвал христитгэгч хүн зуурдын хэрэгцээнийхээ төлөө санаа зовохгүйгээр Эзэний дуудлагыг дагах хэрэгтэй. Бурхан дуудсан хүнийхээ хэрэгцээг заавал хангадаг. "Бурханы

замаар хийгдсэн Бурханы ажилд Бурханы хангамж хэзээ ч дутдаггүй." (Хадсон Тэйлор)

12. Ажил бизнесийн амжилтыг шүтсэн энэ нийгэмд христитгэгч хүн тийм ололт амжилтад нүдээ унагадаггүй байх хэрэгтэй. Өчүүхэн ажлаар Христэд ашиглагдах нь эзэн хаан байхаас дээр. Бурханы хүслийн дотор хог түүгч байх нь Бурханы хүслийн гадна улс орны ерөнхийлөгч байхаас хавь илүү.

Тэгэхээр цаашид ямар ажил хийх тухайгаа бодож буй залуу итгэгч эдгээрийг бодож үзээрэй. Бурхан ямар нэг ажилд орохыг замчилсан нь үнэн л бол тэр нь Эзэнд болзолгүйгээр өөрийгөө өргөхөд хэзээ ч саад тотгор болдоггүй юм шүү!

## ШАЛТАГ, ШАЛТГААН ТООЧИХУЙ

Христэд бүх амьдралаа өргөх тухай ярихаар хүмүүс янз бүрийн шалтаг шалтгаан тоочиж түүнээс зайлсхийхийг оролддог. Өмнөх бүлэгт тэдгээр шалтгуудын нэгийг буюу "Би тэгээд яаж амьдрах юм бэ?" гэдэг тайлбарын тухай ярьсан. Тэгвэл одоо Аврагчийн дуудлагад "үгүй" гэж хэлэхдээ тавьдаг өөр зарим шалтгийг авч үзье.

Хамгийн түгээмэл шалтаг тайлбар: "Би ирээдүйгээ бодох ёстой."

Хэдэн жилийн өмнө зүүн мужид нэгэн залуу тодорхой нэг үйлчлэлд орж Эзэнд үйлчлэх талаар нухацтай бодож байлаа. Түүний дотор Эзэний дуудлага хүчтэй байсан бөгөөд уг дуудлагыг биелүүлэх нь яаралтай байв. Гэтэл нөгөө талд өндөр цалинтай ажлын санал түүнд иржээ. Залуу эргэлзэж тээнэгэлзсэн учраас ажил бизнесийн талбарт амжилттай яваа настай хоёр итгэгчээс зөвлөгөө авав. Тэд түүнийг ажилд орох ёстой хэмээн ятгаж, "Боб, чи ирээдүйгээ бодох ёстой шүү дээ" гэж зөвлөжээ.

Залуу ч өндөр цалинтай ажлыг сонгосон юм. *Гэхдээ тэр үнэхээр ирээдүйгээ бодсон гэж үү?*

Зарим хүн "Хэн нэгэн нь гэртээ байх хэрэгтэй" гэж шалтаг хэлдэг. Энэ үгийг хэлэгсэд нь Христийн төлөө галын шугамд үйлчилж байгаа хүмүүсийг бодож буй мэт

харагдавч үнэндээ тийм үйлчлэлд дуудагдах эрсдэл хүлээх хүсэлгүй байгаагаа далдлах гэсэн оролдлого байх нь олон. Бурхан сайнмэдээний төлөө үйлчилж байгаа хүмүүсийг дэмжих үүднээс зарим хүмүүсийг гэрт нь үлдээдэг. Гэвч эрүүл чийрэг, зориг зүрхтэй, авьяас чадвартай олон залуучууд гэртээ үлдээд, харин сул дорой эмэгтэйчүүд нь аюултай талбар руу дуудагдсан байна гэвэл учир дутагдалтай санагдаж байна.

Зарим хүн өөрсдийн авьяас чадвар, эрдэм мэдлэгийг Христийн үйлчлэлээс өөр газар зориулагдах ёстой гэж үздэг. Эзэн өөрсдийнх нь зэрэг зиндаанаас доогуур үйлчлэлд дуудчих вий гэж айснаасаа болоод Эзэнд бүх зүрхээрээ амьдралаа өргөхөөс хойш суудаг. Үүнд хариу өгөх амархан. Авьяас чадвар маань хаана хамгийн сайн ашиглагдах вэ гэдгийг шийдэх нь бидний хэрэг биш. Харин юуг тунгааж үзэх ёстой вэ гэвэл, бидэнд байгаа ямар нэг зүйл Бурханд гоёдно гэж бодох нь Бурханыг доромжилсонтой адил юм шүү! Бид бүх зүйлийг Бурханаас хүлээн авсан. Боловсрол, авьяас чадварт буруу юм байхгүй боловч тэдэнд тохирох хамгийн зөв газар бол Эзэн Есүс Христийн хадаас зоолгосон хөл билээ. Элч Паул өндөр боловсролтой, хичээл зүтгэлтэй, авьяас чадвартай хүн байсан. Ертөнцийн нүдэнд үнэтэйд тооцогдох энэ чанаруудынхаа тухай тэрээр юу гэж



бичсэнийг сонсоно уу. "Гэвч миний хувьд ололт байсан болгоныг би Христийн төлөө хохирол болгон тооцов. Тэр ч байтугай, би Христ Есүс Эзэнээ танин мэдэхүйн хосгүй давуу талын төлөө бүх юмсыг хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд билээ" (Флп 3:7,8).

Христэд бүхнээ өргөх тухай ярихаар "Даан ч би хөгширчээ" гэж хэлдэг хүмүүс бий. Тэднээс би "Дуулгавартай дагахад хөгшиднө гэж байх уу?" гэж асуумаар байна.

Зарим хүн гэр бүлийнхнийхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаараа шалтаг тоочдог. Эцэг эх, эхнэр хүүхэд минь яах билээ гээцгээдэг. Бурханд өөрийгөө өргөхөд саад болдог юм бол Тэр бидэнд хайртай хүмүүсийг минь өгөх байсан гэж үү? Бурхан өөрийн хүсэл зорилгод саад хийнэ гэж үү? Мэдээж үгүй. Христийн төлөө амь амьдралаа зориулна гэдэг нь гэр бүлийнхнийхээ өмнө хүлээсэн үүргээ умартана гэсэн үг биш ээ. Гэхдээ бидний нэн тэргүүний үүрэг болбоос Бурханд өөрийгөө өргөж, Бурханыг "өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээс" төдийгүй "өөрийн аминаас" илүү хайрлах явдал билээ (Лк 14:26).

Үнэн сүсэгт зарим нэг нь бэлэг авьяасгүй хэмээн хойш суудаг. Гэхдээ Бурханд өөрийгөө өргөхийн тулд бэлэг

авьяастай байх шаардлагагүй. Харин ч Христ хоосон савыг илүү ашигладаг. Ихэнх тохиолдолд хүний өнцгөөр сул дорой харагдсан нэгнийг Эзэн өөрийн ажилдаа дууддаг. Тэгэхээр бэлэг авьяасгүй гэх хандлага учир дутагдалтай. Дээр нь нэмж хэлэхэд, Христийн биеийн эрхтэн бүр ямар нэг бэлэгтэй гэж Бурхан хэлдэг. Биеийн аль хэсэгт ажиллах ёстойгоо мэдэхийн тулд эхлээд Эзэн Есүсийг дуулгавартай дагах ёстой.

Зарим нь "Бурхан намайг өөрийнх нь төлөө бүхнээ өгөөсэй гэж хүсдэггүй. Харин миний хүсэж байгаа эсэхийг мэдмээр байгаа" гэж хэлдэг. Магадгүй энэ нь хамгийн өрөвдөлтэй шалтаг биз ээ. Цэргүүд фронтын шугам дээр байна гэж бодъё. Давших тушаал ирэх үед тэд нуувчнаасаа гаралгүй, буу зэвсгээ өнгөлөн зүлгэж суусаар "Генерал биднийг урагш давшаасай гэж хүсээгүй. Харин бидний давшихыг хүсэж байгаа эсэхийг мэдмээр байгаа" гэж хэлбэл юу болох вэ? Ийм хандлагаар тулаанд ялдаггүй юм. Энэ нь зөвхөн ялагдлыг авчирна.

Хүн Христэд өөрийгөө өгөхөөс хойш суухдаа эдгээр шалтгуудыг хэлдэг. Эдгээр нь шалтаг болохоос үнэн зөв үндэслэл биш. Үнэндээ Аврагчид амь амьдралаа зориулах үүрэг хариуцлагаас зугтах ямар ч үндэслэл бидэнд байхгүй.

*Тэр бидэнд дахин нэг удаа "Хүү минь (Охин минь), надад зүрхээ өг" гэвэл та түүнд ямар хариу барих вэ? Шалтаг тоочих уу? Өөрийгөө өргөх үү?*

## ГАЛ ХАЛУУН АМЬДРАЛ

Эзэн Есүс Христ үнэ цэнтэй Нэгэн мөн л юм бол бүхнийг минь авах үнэ цэнтэй байж таарна. Тэр бидний төлөө үхсэн нь үнэн л юм бол бид ч түүний төлөө үхэх ёстой. Тэр бидэнд Өөрийн биеэ зориулсан юм бол бид өөрсдийн биеэ Түүнд өгөх учиртай.

Жинхэнэ итгэгч Христийн шүтэн бишрэгч байдаг. Ямар ч доромжлол буруутгал ирсэн тэрээр энэ ертөнцтэй нийлдэггүй. Христитгэгч хүн бусдын адил болоод ирэхээрээ жинхэнэ мөн чанараа гээдэг.

Жинхэнэ итгэгч халуун сэтгэлээр амьдардаг. Түүний дотор Христийн төлөө гэсэн гал асаж явдаг. "Надад ганцхан хүсэл тэмүүлэл бий. Тэр бол зөвхөн Христ" гэж Цинцендорф гүн хэлжээ. Христээс бусад нь дагалдах зүйлс юм.

Бурханы хүмүүс Христийн төлөө ямар ч золиосыг өргөхөд бэлэн байдаг. Тэд өөрсдийн мөнгө, цаг хугацаа, амь насаа ч Эзэнд баяр хөөртэйгөөр өгдөг.

Тэд Роберт Артингтон шиг "Христийг таньж мэдэлгүйгээр хэн нэг хүн мөхсөнөөс би шалан дээр унтаж, цаасан хайрцгаар сандал ширээгээ хийхийг илүүд үзнэ" гэж хэлдэг.

Христийн дагалдагчид бусдын адил амьдардаггүй. Тэд төрөлх зөнгөө дагадаггүй. Тэд амьдралын хүлээсэнд уягддаггүй. Тэд Христийн төлөө эдлэх эрхээсээ татгалздаг. Христийн дагалдагч нь боолууд бөгөөд бусдыг ноёлох юм уу өөрсдийн амьдралын эзэн байхаас татгалздаг аж. Тэд зөвхөн Христийг дагадаг.

Жинхэнэ христитгэгч хүн бол харь нутагт яваа цагаач, түр оршин суугч бөгөөд тэр нутгийнханд үнэнийг итгэмжтэйгээр гэрчлэгч юм. Гэхдээ тэр нутгийн зан заншлыг дагадаггүй.

Тэрээр найз нөхөдтэй болох гэж хичээдэггүй, ертөнцийн сайн сайханд найдвар тавих юм уу тэдгээрийг хүсдэггүй, гарз хохиролд ч гутардаггүй, амьдралын хэрэгт оролцдоггүй, үхлээс ч айдаггүй нэгэн юм. Түүнд зэрэг зиндаа, эх орон аль нь ч байхгүй. Түүнд ганц л бодол бий. Тэр нь Христийн сайнмэдээ. Түүнд ганц л зорилго бий. Тэр нь Бурханы алдар. Тэрээр Христийн төлөө мунхаг болоход бэлэн. Ертөнц түүнийг тохуурхаж, туйлшрагч, галзуу солиотой, ухаанаа алдсан гэх мэтээр юу ч гэж нэрлэсэн тэр гутардаггүй. Ертөнц түүнийг яаж ч шагшин магтан сайшаасан тэр сагсуурдаггүй. Тэд ярих ёстой бол ярьж, үхэх ёстой бол үхдэг. Тэд амарч тухлахыг огтхон ч бодохгүй. Далай тэнгис, уул хад, говь цөл хаана ч байсан хүмүүсийг

аврахын төлөө яаравчилдаг. Шоронд байхдаа ч тэд дуугаа өндөрсгөдөг. Далай тэнгисийн давлагаа намжсан ч чимээгүй болдоггүй. Хатуу шүүх, эрх мэдэлтэн, эзэн хаадын өмнө тэд үнэний нэрийн өмнөөс ярьдаг. Үхлээс өөр юу ч тэдний амыг барьж чадахгүй. Ямар ч үхэл тулгасан тэд ярьсаар, залбирсаар, тунхагласаар, тэмцсээр, харгис этгээдийг ерөөсөөр байдаг.

Эзэн Есүс өнөөдөр ийм хүмүүсийг хайж байна. Тэр өмнө нь ч хайж байсан. Одоо ч хайж байна. Тэр Өөрийг нь ямар ч утга учиргүй дагадаг сүрэг олныг биш, харин Өөрийнх нь алхсан замаар амь биеэ үл хайрлан дагах хүмүүсийг хайж байна.

Тэрээр "чин зүрхнийхээ угаас төөнөм халуун үгээр" номлодог Ровлэнд Хилл шиг хүмүүсийг хүсдэг. Тэрээр амь биеэ хайрлаагүй Чалмерс шиг хүмүүсийг хайдаг. Тэрээр "одоо намайг Бурханы төлөө шатаагаад аль" гэж хэлсэн Хэнри Мартин шиг хүмүүсийг эрдэг.

Өнөөдөр олон залуу хүн бизнесийн төлөө амьдралынхаа шилдэг он жилүүдийг өгөхөд бэлэн байна. Тэд эх орныхоо төлөө үхэхийг хүсдэг. Тэд сайн цалингийн төлөө дэлхий даяар аялахад бэлэн. Мөн улс төрийн намын төлөө өдөр шөнөгүй ажилладаг.

Хөгжимчин болохын тулд хурууныхаа өндгийг цоортол хичээллэдэг. Санваартан болохын тулд хүнтэй суухгүй гэсэн хатуу тангараг тавьдаг. Жүжигчин болохын тулд маш урт хэцүү зохиолуудыг цээжилдэг. Ажил мэргэжилтэй болохын тулд бүтэн арван жилээ сурахад зориулдаг. *Харин та Эзэн Есүсийн төлөө юу хийхэд бэлэн байна вэ? Та зүрхнийхээ талыг биш бүгдийг өргөхөд бэлэн үү?*

